

# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

25  
ЖИЛ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2019 · 7 сар | Дугаар 9

## ГАРЧИГ

**2–6** Нийтлэл – Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал

**7–9** Санхүүгийн салбарт итгэх итгэлийг бий болгох чухал хөшүүрэг нь хяналт шалгалт

**10–12** Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдэд хүргэх нийтлэг зөвлөмж

**13–14** Амьдралын даатгал эдийн засагт

**15** Санхүүгийн салбарын комплаенс хэлэлцүүлэг 2019

**16–17** Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрхийн хамгааллын өнөөгийн байдал

**17–24** Хяналт шалгалтын мөрөөр



## Мөнгөжилгээ

Дэлхийд биднээс өөр ямар ч улс орон тэмдэглэдэггүй морьтон ардын цог золбоо, тал нутгийн яруу гайхамшигийг илтгэн харуулдаг Үндэсний их баяр наадам эхэллээ. Бяр хүч, цэц хурдаа сорьж, хүмүүний баяр баясгалан, хүүхдийн хөөр хөгжөөн, хүлэг морьдын хиймориор уудам цэлгэр Монголын тал нутаг эгшиглэн шуранхайлж байна. Нар, хур тэгшрэн жигдэрсэн долдугаар сарын цэнхэр тэнгэр асрын дор их цэнгэлийг үүсгэн баярлаж буй наадамчин

олондоо эгэлгүй ганц, эгнэшгүй их баяр наадмын мэндийг өргөн дэвшүүлье.

Энэ жил Монгол Улсад санхүүгийн зохицуулагч байгууллага үүсч, хөгжсөний 25 жилийн ой болж, СЗХ болон зохицуулалтын байгууллагуудын хувьд баярт үйл явдал тохиож байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн болон хадгаламж зээлийн хоршооны салбарыг бодлого зохицуулалтаар ханган, шинэ технологи, бүтээгдэхүүнүүдийг цаг алдалгүй нутагшуулж, дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхахыг хичээн ажиллаж байна.

Монголын банкнаас бусад санхүүгийн салбарт сүүлийн 20 жилд үзэгдээгүй өндөр өсөлт өнгөрсөн хоёрхон жилд бий болж, даатгал, хөрөнгийн зах зээл, ББСБ, ХЗХ-ны голлох үзүүлэлтүүд 30 гаруй хувиар өсч, зах зээлийн бодит сэргэлт бий болов. 2018 онд нэрлэсэн ДНБ-д эзлэх банкнаас бусад санхүүгийн салбарын хувь хэмжээ 16 хувьд хүрсэн нь Монгол Улсын макро эдийн засагт үзүүлж буй тус зах зээлийн нөлөө далайцтайгаар өргөжиж буйг харуулж байна.

Бид Монгол зондоо өгөөжтэй, малчин түмэндээ хүртээмжтэй, хөгжил дэвшлийн алхаанд тогтвортой, өндөр чадвартай зах зээлийг төлөвшүүлэн цогцлоохын төлөө үнэт цаасны, даатгалын, банк бус санхүүгийн болон хадгаламж зээлийн хоршооны салбарын бизнес эрхлэгчид, харилцагч үйлчлүүлэгч олонтойгоо санаа зорилго, гар сэтгэлээ нийтгэн ажиллаж, өдөр өдрөөр ахин дэвшиж, өөдлөн урагшилж байна.

Олсон ололт, хүрсэн амжилтаа улам бататгаж, монгол айл бүхний гал голомтыг санхүүгийн өгөөж, хишгээр тэгш бадраан, монгол хүн бүхнийг мөрөөдөл хүслээ биелүүлэхэд нь дэм болох хүртээмжтэй, улс орны хөгжил цэцэглэлтийн нөхцлийг хангах хүрэлцээтэй, сайн засаглал, өндөр чадавх бүхий санхүүгийн тогтвортой тогтолцоог хамтаараа батжуулан бэхжүүлж чадна гэдэгт эргэлзэхгүй байна.

*Дээдсээс өвлөсөн их цэнгэл баяртаа дэлхийг шагшуулан, сайхан наадаарай!*

## Санхүүгийн зохицуулах хорооны

### АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

### ҮНЭТ ЗҮЙЛС

**Цогц мөн чанар:** Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

**Хариуцлагатай байх:** Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

**Мэргэжлийн байх:** Өндөр мэдлэг, үр чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

**Бие даасан байх:** Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

**Манлайлал, санаачлагатай байх:** Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

**Багаар ажиллах:** Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

**Бидний үнэт зүйлс юм.**

## Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хороо товхимол

Монгол Улс, Улаанбаатар хот 15160  
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3  
Засгийн газрын IV байр.

976 51 261611

[press@frc.mn](mailto:press@frc.mn)

[www.frc.gov.mn](http://www.frc.gov.mn)

Санхүүгийн зохицуулах хороо

@FRC\_of\_Mongolia

Хэвлэл мэдээллийн алба

## ГОЛЧ – НИЙТЛЭЛ

### МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

Монгол улсад сүүлийн жилүүдэд тулгараад буй нэг томоохон асуудал нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах олон улсын байгууллага буюу ФАТФ /Financial Action Task Force/-ын “саарал жагсаалт”-д орж болзошгүй эрсдэл юм. Иймээс тус жагсаалт чухам юу болох, ямар шалтгааны улмаас өнөөгийн нөхцөл байдалд орсон, уг жагсаалтад орсноор цаашид ямар эрсдэлүүд үүсч болох талаар өгүүлье.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх (МУТС) гэмт хэргүүдийн нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь өндөр байдаг бөгөөд ихэвчлэн “цагаан захтнууд” буюу эрх мэдэлтэй албан тушаалтнууд оролцсон, олон салбар, бизнесийг хамарсан, зохион байгуулалттай, улс хооронд дамжин үйлдэгддэг байна. Ийм учраас МУТС гэмт хэрэгтэй тэмцэх нь зөвхөн ганц улс орны хийх ажил биш бөгөөд улс орнууд, ялангуяа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаа ихээхэн шаардагддаг.

### Нэг. Мөнгө угаах гэмт хэргийн талаар

Аливаа гэмт хэрэг ихэнхдээ ашиг, хонжоо олох зорилготой байдаг бол мөнгө угаах гэмт хэрэг хууль бусаар олсон ашиг, орлогын гарал үүслийг нуун дарагдуулж, хууль ёсны мэт харагдуулахыг зорьдог.

Гэмт хэрэгтнүүд авлига, хээл хахууль, хар тамхи, зэвсгийн наймаа, цахим орчин дахь луйвар гэх мэт гэмт хууль бус үйлдлээс олсон хэлбэр, оролцсон этгээдүүдийг нуун далдалж, хууль сахиулах байгууллагын анхаарлыг татахгүйгээр захиран зарцуулах арга замыг олохыг үргэлж эрэлхийлж байдаг. Тухайлбал, эд хөрөнгийн гарал үүслийг нуун далдлах хөрөнгийн хэлбэрийг өөрчлөх, байршлыг өөрчлөх, оффшор бүсээр дамжуулах, эд хөрөнгөтэй холбоотой гүйлгээний ул мөрийг баллах зэрэг маш олон арга хэлбэрийг ашиглаж бохир мөнгийг цэвэршүүлэн хууль ёсны бизнесийг санхүүжүүлэх замаар угаадаг. Өөрөөр “бохир” мөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж “цэвэр” мөнгө мэт харагдуулахыг мөнгө угаах гэмт хэрэг гэж ойлгож болно.

Мөнгө угаах гэмт хэргийн үүслийн тухайд

товч дурдвал манай эриний өмнөх 2,000 жилийн өмнө татвараас зайлсхийж өөрийн орлогоо удирдагчдаасаа нуун өөр газар, өөр улсад шилжүүлж, гадагш хөрөнгө оруулж, эсвэл газарт булдаг байсан хятад наймаачдаас үүсэлтэй гэж үздэг.

Харин “мөнгө угаах” гэсэн нэр томъёо бий болоод удаагүй бөгөөд 1920-оод оны эхэнд АНУ-ын мафиин толгойлогч Аль Капоне гэх этгээд хууль бус үйлдлээсээ олсон орлогоо өөрийн угаалгын газраас олсон орлого мэтээр тайлагнадаг байснаас эхэлсэн гэж ярьдаг бөгөөд АНУ-ын 1970 онд батлагдсан Банкны нууцлалын тухай хуульд тус нэр томъёог албан ёсоор тусгаснаар бий болсон гэж үздэг.

Мөнгө угаах гэмт хэрэг нь хавала, хунди аргаар мөнгө дамжуулдаг байсан үеэс эхлэн зуу зуун жил дамжин оршоор криптовалютаар дамжуулан мөнгө угаах боломжтой болсон цаг үед бид ирээд байна. Өнөөдөр мөнгө угаах арга хэлбэрүүд цаг хугацааг даган улам боловсронгуй болсоор байна.

ОУВС болон НҮБ-ын судалгаагаар дэлхийн ДНБ-ий 2–5% буюу 800 тэрбумаас 2 их наяд америк доллартой тэнцэхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө гэж тооцжээ. Далд эдийн засагтай холбоотой ийм төрлийн судалгааг хийхэд нарийн тооцоолоход ихээхэн хүндрэлтэй байдаг. Иймд ойролцоогоор таамаглан гаргадаг байна. Монгол Улсад ч мөн адил хууль бус орлогын хэмжээг тодорхойлох, судалгаа хийх бэрхшээлтэй байдаг. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд Монгол Улсад авлига, хээл хахууль, оффшор хөрөнгөтэй холбоотой хэд хэдэн тохиолдол илэрсэн нь цаашдаа энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог сайжруулах шаардлагатайг бидэнд харуулж байна.

Мөнгө угаах үйл ажиллагааг үндсэндээ дараах 3 үе шаттайгаар хийдэг гэж үздэг. Үүнд:

1. Байршуулах үе шат /Placement/: Эхний бөгөөд хамгийн эгзэгтэй үе шатанд хууль бусаар олсон хөрөнгийг хууль ёсны эдийн засагт байршуулж, мөнгөний анхны эс үүсвэрээс “салах”-ыг оролддог. Тухайлбал, гэмт этгээд өөр хүний банкны дансанд хууль бусаар олсон мөнгөө бусдын анхаарал татахааргүй хэмжээтэйгээр хуваан хийх, үнэт цаас, хувьцаа худалдан авах, эсхүл байр, байшин худалдан авах замаар байршуулж

болно;

2. Нуун далдлах үе шат /Layering/: Гарал үүслийг нь нуун далдлах, хууль ёсны орлого мэт харагдуулах зорилгоор нэгэнт байршуулсан мөнгөө дахин эргэлтэд оруулдаг. Жишээ нь, худалдан авсан үнэт цаасаа эргүүлэн зарах эсвэл гадаад худалдаа эрхэлж буй мэт харагдуулах зорилгоор мөнгө угаахтай тэмцэх хяналтын механизм бүрдээгүй орнууд руу шилжүүлэх гэх мэт аргыг хэрэглэдэг;

3. Буцаан төвлөрүүлэх үе шат /Integration/: Нэгэнт гарал үүслийг нь тогтооход бэрх болсон эсхүл хууль ёсны мэт харагдах болсон мөнгөө эргүүлэн өөрийн нэр дээр төвлөрүүлдэг үе шат. Тухайлбал, үнэтэй үл хөдлөх эд хөрөнгө худалдаж авах, хууль ёсны бизнест хөрөнгө оруулах гэх мэтээр өөрийн нэр дээр татан төвлөрүүлдэг байна.

**Хоёр. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаар**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд “терроризмыг санхүүжүүлэх” гэж террорист байгууллага, террорист хүн, эсхүл террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг хэлнэ гэж томъёолсон байдаг. Өөрөөр хэлбэл террорист үйл ажиллагааг санхүүжүүлэх, үүнтэй холбоотой байх магадлалтай гүйлгээ хийхийг терроризмыг санхүүжүүлэх гэж нэрлэдэг.

Мөнгө угаах үйл ажиллагааны гол сэдэл нь гэмт хэрэг үйлдэж ашиг хонжоо эрэлхийлэх, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн сэдэл нь үзэл сурталтай шууд холбоотой байдаг ба энэ нь шашин шүтлэг, улс төр, өш хонзон, бэлэг тэмдгийн хэлбэрээр илэрдэг. Террорист үйл ажиллагаа нь бусдын амь насыг санаатай бүрэлгэх, үй олноор хөнөөх, хүн барьцаалах, гэмтээх, түүх, соёлын үнэт өвийг санаатай хорлон сүйтгэх замаар төр засаг болоод олон улсын байгууллагыг аливаа нэг үйлдэл хийлгэхгүй байх явдал.

Мөнгө угаах гэмт хэрэг нь хууль бус орлогыг хууль ёсны мэт харагдуулахыг зорьдог бол терроризмыг хууль ёсны болон хууль бус эх үүсвэрээр аль алианаар нь санхүүжүүлж болдог байна.

**Хууль бус санхүүжилтийн эх үүсвэр:** Айлган сүрдүүлэх, хүн барьцаалж мөнгө нэхэх, хүний наймаа, хар тамхины худалдаа зэрэг хууль бус үйлдлүүд нь санхүүжилтийн томоохон эх

үүсвэр болдог.

Мөн хууль бусаар улс дамжиж бараа тээвэрлэн дамжуулах, залилан, хулгай дээрэм хийх, хувийн мэдээллийг хулгайлж мөнгө нэхэх, хууль бус үйл ажиллагаа эрхлэх зэрэг үйлдлүүдийг мөн дурдаж болно.

**Хууль ёсны санхүүжилтийн эх үүсвэр:** Хууль ёсны санхүүжилтийн эх үүсвэрийг гадны улс орнуудын төр засгаас өгсөн хандив, тусламж, бизнес болон хувиараа хөдөлмөр эрхэлж олсон хууль ёсны орлого зэргүүд бүрдүүлнэ. Харамсалтай нь зарим тохиолдолд хандивлагчид өөрийн хандивласан хөрөнгийг

терроризмыг дэмжсэн үйл ажиллагаанд чиглэгдсэн талаар мэдэхгүй байх явдал ч гардаг. Хууль ёсны байгууллагууд ч мөн террорист байгууллагуудыг мэдэлгүйгээр санхүүжүүлэх тохиолдлууд бий.

Терроризмыг санхүүжүүлэх асуудлын хүрээнд үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудлыг мөн тусгадаг. ФАТФ-ын 7 дугаар зөвлөмжид улс орнууд үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэх ажиллагаанаас сэргийлэхтэй холбоотой арга хэмжээг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолд нийцүүлэн авч хэрэгжүүлэхийг зөвлөсөн байдаг.

**Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргүүдийн ялгаа:**

	Мөнгө угаах	Терроризмыг санхүүжүүлэх
<b>Сэдэл</b>	Ашиг хонжоо	Үзэл суртал
<b>Эх үүсвэр</b>	Ихэвчлэн хууль бус үйл ажиллагаанаас олсон орлого	Хууль ёсны болон хууль бус үйл ажиллагаанаас олсон орлого аль аль нь байх боломжтой
<b>Хэмжээ</b>	Их дүнтэй	Ихэвчлэн бага дүнтэй
<b>Арга хэлбэр</b>	Нуун далдлах арга техникүүдийг ашиглаж хөрөнгийг жинхэнэ эх үүсвэрээс нь холдуулах бүх арга хэмжээг авах	Ихэвчлэн албан бус шилжүүлэг, гадаад валют арилжааны төвүүдийг ашиглаж эцсийн хэрэглэгч рүү мөнгийг чиглүүлэх
<b>Эцсийн зорилго</b>	“Бохир” мөнгийг угааж хууль ёсны санхүүгийн системд нийлүүлэх	Террорист үйл ажиллагааг дэмжих
<b>Хөрөнгийн урсгал</b>	Дугуй буюу хөрөнгө анхны эзэндээ эргэж очно	Шугаман буюу хөрөнгө анхны эзэндээ эргэж ирэхгүй

**Гурав. МУТС гэмт хэрэгтэй тэмцэх шаардлага, тогтолцоо**

Дэлхий нийтээр МУТС тэмцэх асуудалд 2001 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр АНУ-д болсон террорист халдлагаас хойш онцгой анхаарч эхэлсэн. Уг террорист халдлагыг хэн, ямар мөнгөөр санхүүжүүлж, хэрхэн зохион байгуулсан талаар зарим асуудал сөхөгдөж, эрчимтэй арга хэмжээ авах болов.

Өмнө Франц улсын Парис хотод болсон Их 7-гийн уулзалтаар уг төрлийн гэмт хэрэгтэй олон улсын төвшинд тэмцэх зорилгоор 1989 онд байгуулсан ФАТФ-ын үйл ажиллагааг улам идэвхжүүлж, гишүүн улс орнуудад тавих шаардлагуудыг чангаруулж эхлэв. Тус байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТС) чиглэлээр 40 зөвлөмжийг боловсруулан гаргаж, гишүүн улс орнуудыг дагаж мөрдөхийг шаарддаг бөгөөд зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн улс орнуудыг “саарал” болон “хар” жагсаалтад оруулдаг.

Хар болон саарал жагсаалтад багтсан орнуудтай дэлхийн бусад улс орнууд эдийн

засгийн харилцаанд орохоос татгалзаж, хөрөнгө оруулагчид нүүрээ буруулж, цаашлаад улс орны нэр хүнд унаж, эдийн засгийн хямрал болоход нөлөөлдөг.

Тухайлбал, Иран болон Хойд Солонгос улсыг цөмийн зэвсгийг санхүүжүүлж байгаа гэж үзэн хар жагсаалтад оруулсан бол зөвлөмжүүдийг хангалтгүй хэрэгжүүлж буй хэд хэдэн улсыг (Бахама, Боствана, Камбож, Этиоп, Гана, Пакистан, Шри-Ланк, Сири, Серби, Тринадад ба Тобаго, Тунис, Йемен) саарал жагсаалтад оруулсан байна.

ФАТФ гишүүн орнуудад зөвлөмжөө хэрэгжүүлэхийн тулд дэлхий даяар бус нутаг хариуцсан байгууллагуудыг байгуулсан бөгөөд Монгол Улс Ази номхон далайн бүс нутгийн МУТСТ байгууллага /Asia/Pacific Group on Money Laundering – APG/-д харьяалагддаг.

МУТС гэмт хэргийн хор уршиг нь хувь хүний амьдралд шууд нөлөөлөхөөс гадна байгууллагын төвшинд, цаашлаад нийгэм, улс үндэстний төвшинд хүртэл шууд болон шууд бусаар нөлөөлдөг байна. Тухайлбал, МУТС гэмт хэрэг үйлдэгдэх магадлал өндөртэй улсад нийгмийг эмх замбараагүй

байдал бий болох, улс үндэстний энх тайван байдалд заналхийлэл үүсэх, улс төрийн тогтворгүй байдал үүсэх, зээлжих зэрэглэл буурч, гадаадын хөрөнгө оруулалт саарч санхүүгийн хямралд өртөх зэрэг нийгэм, эдийн засгийн эрсдэлүүд үүсч болзошгүй. Иймээс ФАТФ–ын зөвлөмжийг хэрэгжүүлж “хар”, “саарал” жагсаалтад орохгүй байх нь манай орны хувьд маш чухал сорилт юм.

**Дөрөв. Монгол улсын МУТСТ чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ**

Монгол Улс 2003 онд “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенц”–д нэгдэн орж, 2004 онд Ази, Номхон далайн бүс нутгийн МУТСТ байгууллага (APG)–д элсэн орсноор МУТСТ олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээх болсон. Улмаар манай улс 2006 онд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2004 онд Терроризмтой тэмцэх тухай хуулийг тус тус баталсан байна. МУТСТ тухай хуулийн дагуу Санхүүгийн мэдээллийн алба (СМА) байгуулагдаж, мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийн, эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх үүргийг хэрэгжүүлж эхэлсэн билээ.

ФАТФ болон түүнтэй ижил төрлийн бүс нутгийн олон улсын байгууллагууд өөрийн гишүүн улс орнуудыг МУТСТ зөвлөмжүүдийг хэрхэн хэрэгжүүлж байгааг тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлж, хянадаг бөгөөд Монгол улсад анхны “Харилцан үнэлгээ”–г 2007 онд хийсэн байдаг. Энэ Харилцан үнэлгээний тайланд Монгол улс ФАТФ–ын тухайн үеийн зөвлөмжүүд буюу 40 үндсэн, 9 тусгай шалгуураас 21–ийг биелүүлээгүй, 15–ыг хэсэгчлэн биелүүлсэн гэсэн үнэлгээ авч байжээ.

Энэхүү үр дүнгээс шалтгаалан 2011 онд Олон улсын хамтын ажиллагааг хянах бүлэг буюу ОУХАХБ (International Cooperation Review Group – ICRG)–ээс Монгол улсын МУТСТ тогтолцоог өөрийн хяналтад оруулахаар болж, улмаар 2013 онд Монгол улс ФАТФ–ын “саарал жагсаалт”–д орж байсан.

Уг жагсаалтад орох үед Монгол Улсын эдийн засаг өндөр өсөлттэй, гадаад нэр хүнд сайн байсан зэргээс шалтгаалан эдийн засагт учирсан бодит хохирол харьцангуй бага байсан боловч Европын бүх банкууд манайхаас харилцаагаа тасалж байсан бөгөөд манай улс Хятадын банкаар гадаад гүйлгээгээ дамжуулснаар өндөр шимтгэл төлж байв.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газар шуурхай арга хэмжээ авч МУТСТ тухай хууль, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулан холбогдох журам, заавруудыг богино хугацаанд баталсны үр дүнд 2014 онд тус жагсаалтаас гарсан байдаг.

Ази, Номхон далайн бүс нутгийн МУТСТ байгууллагаас 2016–2017 онд хоёр дахь удаагийн харилцан үнэлгээг хийсэн. Энэ удаад ФАТФ–ын 2012 онд гаргасан 40 зөвлөмжийн дагуу Техникийн хэрэгжилт (хууль, эрх зүйн болон үйл ажиллагааны тогтолцоо) болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг (хэрэгжилтийн түвшин) үнэлдэг шинэчилсэн аргачлалаар үнэлжээ. Харилцан үнэлгээгээр Монгол улсын МУТСТ чиглэлээр 2013–2016 оны хооронд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг үнэлж, дүгнэсэн бөгөөд 40 зөвлөмжөөс 5–ыг биелүүлээгүй, 15–ыг хэсэгчлэн биелүүлсэн гэсэн үнэлгээ өгсөн байна.

Мөн Монгол Улсыг ОУХАХБ–ын “эрчимтэй хяналт”–д оруулж, саарал жагсаалтад орохгүй байх, орсон тохиолдолд саарал жагсаалтаас богино хугацаанд гарахын тулд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөгөөг өгч 2018 оны 10 дугаар сараас өмнө хэрэгжүүлэх, явцыг тайлагнах үүрэг даалгаврыг өгсөн. Монгол улсын идэвхтэй ажиллагаа, холбогдох хүсэлтүүдийг илгээж байсны хүчинд дээрх хугацааг 2019 оны 10 дугаар сар хүртэл сунгах ховорхон боломжийг олгосон байна.

Монгол улс эдгээр зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангах чиглэлээр өнгөрсөн хугацаанд идэвхтэй ажиллаж ирсэн бөгөөд СМА–ны дэргэд холбогдох Яам, агентлагуудыг оролцуулсан Хамтын ажиллагааны зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Энэхүү зөвлөлд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Гадаад харилцааны яам, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Хууль зүйн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн алба, Авлигатай тэмцэх газар зэрэг байгууллагын төлөөллүүд багтдаг.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”–ийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргийг мөнгө угаах,

терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлэх харилцан үнэлгээний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Үндэсний зөвлөл ажиллаж байна.

МУТСТ тогтолцоо дараах байдлаар ажилладаг. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчин, хууль тогтоох ажиллагаа;
2. Төрийн хяналт шалгалт /Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах/;
3. Зөрчил шалгах ажиллагаа /Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газраас зөрчлийн хуульд заасан МУТСТ холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэх/;
4. Сэжигтэй гүйлгээ, харилцагчийг таньж мэдэх ажиллагаа;
5. Сэжигтэй гүйлгээг мэдээлэх, дотоод хяналт /Банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, нотариатч/;
6. СМА нь мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд МУТСТ холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх;
7. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих /Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн мэдээллийн алба/;
8. МУТСТ суурь гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах /Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар/;
9. МУТСТ суурь гэмт хэрэг, зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналт;
10. Мөнгө угаах гэмт хэрэг болон МУТСТ суурь гэмт хэрэг, зөрчлийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа;
11. Хамтын ажиллагааны зөвлөл.

**Тав. Дүгнэлт**

Өмнө “саарал” жагсаалтад орох үеийн нөхцөл байдал одоо учирч буйгаас өөр юм. Учир нь 2016–2017 онд хийгдсэн хоёр дахь удаагийн харилцан үнэлгээ нь эхний үнэлгээтэй харьцуулахад ФАТФ–ийн шинэ аргачлалаар хийгдсэнээрээ ялгаатай байсан тул энэ удаагийн жагсаалтад орох эсэх шалгуур мөн өөр.

Өмнө зөвхөн техникийн хэрэгжилтийн зөвлөмжид үндэслэн үнэлэхдээ Монгол Улсад МУТСТ холбоотой хууль тогтоомж байгаа эсэхийг харгалзан үзэж байсан бол энэ удаад эдгээр хуулийн хэрэгжилтийн асуудлыг давхар үнэлэх юм.

Хууль эрх зүйн орчин бүрдсэн боловч хэрэгжилт тун тааруу байгаа талаар АНДББ–аас удаа дараа онцолж байгаа. Тухайлбал, Харилцан үнэлгээний тайланд “Хууль сахиулах байгууллагууд мөнгө угаасныг магадлах нь олонтаа ч мөрдөн шалгах ажиллагаа ердөө 49 тохиолдол нийцсэн гэжээ.

Эдгээрээс зөвхөн 2 хэрэгт мөнгө угаах зүйлчлэлээр ял шийтгэл оногдуулсан ч мөнгө угаах гэмт хэргээр зүйлчилсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг Дээд шүүхээс хэрэгсэхгүй болгосон” талаар онцлон дурджээ.

Мөнгө угаах гэмт хэргүүд ийнхүү шүүн таслах шатанд очихгүй байгаа, зүйлчлэл нь өөрчлөгддөг байдал нь эцсийн дүндээ Монгол улсын Харилцан үнэлгээний Үр дүнтэй байдалд үлэмж сөргөөр нөлөөлж байна. Монгол улс Үр дүнтэй байдлын 11 шалгуурын 9 дээр нь хангалтгүй үнэлгээ авсан нь 2011 оноос хойш мөнгө угаах зүйл ангиар Монгол улс нэг ч хэрэг шийдвэрлээгүйтэй шууд холбоотой.

Мөн харилцан үнэлгээний тайлан гарснаас хойш буюу мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой тоон үзүүлэлтүүд нилээн сайжирсан ч, нийгмийг доргиосон томоохон хэмжээний гэмт хэргүүд шийдэгдэхгүй явсаар байгаа нь энэхүү үнэлгээг ахиулахгүй байхад нөлөөлж болзошгүй байна.

Монгол улс ФАТФ–ын “саарал” жагсаалтад орох эсэхийг тун удахгүй шийдвэрлэх гэж буй энэ цаг үед Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгээс тусгаарлагдах аюул заналхийлж байгааг бодитоор хүлээн авч, эдийн засаг болон нийгмийн тогтворгүй байдал үүсгэхгүйн тулд өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлаа зөвөөр тайлагнаж, амжилттай хамгаалах нь маш чухал.

Мөн “саарал” жагсаалтад орсон тохиолдолд

авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, богино хугацаанд уг жагсаалтаас гарах бэлтгэлтэй байх шаардлагатай. Иймд МУТСТ асуудал нь зөвхөн аль нэг төрийн байгууллага, аль нэг салбарт харьяалагдах асуудал биш гэдгийг нийтээрээ ойлгож, төвшин бүртээ нягт хамтарч ажиллах нь нэн чухал юм.

Аливаа улс орны санхүүгийн систем, эдийн засгийн өсөлтөд мөнгө угаах гэмт хэрэг шууд нөлөөлдөг. Тухайлбал, олон улсын гүйлгээ хаагдаж, гадаадын бизнесийн түншгүй болох, томоохон орны хар саарал жагсаалтад орсон тухай дэлхийд мэдүүлснээр авлигач, гадаадын террорист этгээдүүдийн анхааралд өртөх, санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэх иргэдийн дунд бухимдал санхүүгийн салбарын нэр хүнд буурах гэх мэт эрсдэлүүдтэй учирдаг. Иймд дээрх эрсдэлээс сэргийлж урьдчилан сэргийлэх

дархлааг бий болгох шаардлагатай.

Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх зорилгоор улс орнууд тодорхой арга хэмжээг авч ажиллахыг НҮБ–ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолоор шаардсан байна. Тухайлбал, НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлийн 1267, 1373, 1718, 2231–р тогтоол болон түүнийг даган гарсан бусад эрх зүйн баримтад тодорхойлсон террорист этгээд, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэгч болон байгууллагатай холбоотой эд хөрөнгийг цаг алдалгүй царцааж, эд хөрөнгийг дээр дурдсан этгээдэд ашиглуулахгүй байх бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.

Энэ үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор МУ–ын Засгийн газраас 2019 онд батлагдсан “Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журам”–г хэрэгжүүлж байна.

**ГҮЙЦЭТГЭЛЭЭС ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТ РУУ ШИЛЖИХ ҮЙЛ ЯВЦ**

Монгол Улс зах зээлийн нийгэмд шилжин орсноос хойш банк, санхүүгийн салбарт төрөөс баримтлах бодлогын арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Их Хурлаас Банкны тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай зэрэг бие даасан хууль тогтоомжуудыг баталснаар санхүүгийн тухайлсан салбаруудыг төрийн хяналт, зохицуулалтаар ханган ажиллах болсон.

УИХ–ын 2006 оны 01 дүгээр сарын 25–ны өдрийн 10 дугаар тогтоолоор СЗХ байгуулагдаснаар тухайн үеийн Үнэт цаасны хороо, Монголбанк, Улсын мэргэжлийн хяналтын газрын зохицуулалтад байсан үнэт цаасны зах зээл, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, даатгалын салбарын үйл ажиллагаанд тавигдах хяналт, зохицуулалт шилжсэн билээ.

**Хяналт, зохицуулалтын хүрээнд хууль, журам, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт, тусгай зөвшөөрөл сунгах, түдгэлзүүлэх, цуцлах болон зайнаас тавих хяналт, газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлж байна.**

Зохицуулалттай этгээдүүдийн улирал бүр

санхүүгийн байдалд суурилсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланд зайны хяналт шалгалт хийдэг.

Санхүүгийн зохицуулах хорооноос дүрэм журамд суурилсан хяналтыг халж зохистой байдлын хяналт руу шилжиж байгаатай хамруулж гүйцэтгэлд суурилсан хяналт, шалгалтаас эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг зохицуулалтын салбаруудад нэвтрүүлэх чиглэлээр бэлтгэл ажлыг дараах байдлаар хангаад байна. Үүнд:

**Үнэт цаасны зах зээлийн тухайд,** мэргэжлийн оролцогчдын төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих журам, зайны болон газар дээрх хяналт, шалгалтын заавар зэрэг 3 зохицуулалтыг Хорооноос өнгөрсөн хугацаанд батлаад байна:

1. “Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох түүнд хяналт тавих журам”;
2. “Үнэт цаасны зохицуулалттай этгээдийн газар дээрх хяналт, шалгалтын заавар”;
3. “Үнэт цаасны компанийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих заавар”.

Дэлхийн банкны зөвлөхийн тусламжтайгаар Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх /Strategy and road map for risk based supervision/ баримт бичгийг 3 үндсэн чиглэлийн хүрээнд боловсруулсан:

1. Эрсдэлийг тодорхойлох;
2. Эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалтын арга зам;
3. Хяналт шалгалтын үр дүн.

Мөн стратегийг хэрэгжүүлэх хүрээнд мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх гарын авлага болон дараах ажлын баримтуудыг боловсруулаад байна.

**Даатгалын салбарын тухайд**, урт хугацааны болон ердийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих болон даатгалын байгууллагад хийх газар дээрх хяналт, шалгалтын журмууд, хяналтын хуудас, түр зааврыг Хорооноос батлаад байна:

1. “Урт хугацааны даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх журам”;
2. “Даатгалын байгууллагад хийх газар дээрх хяналт, шалгалтын журам”;
3. “Ердийн даатгалын компанийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”;
4. Түр заавар, хяналтын хуудас:

**Хавсралт 1.** Даатгалын компанийн эрсдэлийн удирдлагын түр заавар;

**Хавсралт 2.** Эрт анхааруулах шинжилгээ хийх зөвлөмж /Early warning system/;

**Хавсралт 3.** Ердийн даатгагчийн эрсдэлийн хяналтын хуудас;

**Хавсралт 4.** Урт хугацааны даатгагчийн эрсдэлийн хяналтын хуудас;

**Хавсралт 5.** Даатгалын зуучлагчийн эрсдэлийн хяналтын хуудас.

Люксембургийн МОН/004 болон Дэлхийн банкны төслийн хүрээнд “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хэрэгжүүлэх журам”-ын төсөл боловсруулагдсан, хянан шалгагчийн гарын авлага, даатгагч өөрийн эрсдэл, төлбөрийн чадвараа тооцох (ORSA) тайлан гаргах заавар, даатгалын мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хэрэгжүүлэх журмыг баталснаар даатгалын байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлээд байна.

**Банк бус санхүүгийн байгууллагын тухайд**, ББСБ-ын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх шалгалт хийх журмуудыг Хороо баталсан.

“Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх MON9152 төсөл”-ийн хүрээнд “Бичил санхүүгийн зах зээлийн хянан шалгагчийн гарын авлага”-ыг боловсруулж, гарын авлагад тулгуурлан ББСБ-уудын өнгөрсөн онуудын жилийн эцсийн нэгдсэн тайлангуудад санхүүгийн шинжилгээ болон улирлын санхүүгийн тайлангуудад эрсдэлийн үнэлгээ хийгээд байна.

Цаашид ББСБ-ын зээл болон итгэлцлээс бусад үйл ажиллагааны гарын авлага, эрсдэлийн хүрээ, томъёолол, ББСБ-ын дотоод хяналтын үйл ажиллагааны заавар зөвлөмжийг боловсруулах, “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, санхүү, төлбөрийн чадварт үнэлгээ, дүгнэлт өгөх аргачлал”, “Бичил санхүүгийн зах зээлийн хянан шалгагчийн гарын авлага”-ыг баталгаажуулснаар эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх боломж бүрдсэн.

**Хадгаламж, зээлийн хоршооны тухайд**, ХЗХ-ны үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх, үнэлгээ өгөх заавар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмыг баталж, дараах бэлтгэл ажлуудыг хангаад байна:

1. ХЗХ-ны эрсдэлд суурилсан хяналтын тогтолцооны бодлогын баримт бичиг / Risk based supervision Framework/-ийн төсөл, хянан шалгагч болон СЗХ-ны дотоод хэрэгцээнд зориулан газар дээрх шалгалтын гарын авлагын төсөл;
2. Нийт 290 ХЗХ-г хамарсан ХЗХ-дын тогтвортой хөгжлийг хангах, эрсдэлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, чадавхижуулах талаарх олон улсын сайн туршлагыг хуваалцах орон даяар бүсчилсэн сургалт;
3. ХЗХ-ны санхүүгийн мэдээлэлд үндэслэн зайнаас шинжилгээ хийх, эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн 5 түвшингээр ангилал тогтоох аргачлал, хянан шалгагч нар нийт ХЗХ-дын санхүүгийн тайланд эрсдэлийн үнэлгээний туршилт;

Үнэлгээгээр хамгийн өндөр эрсдэлтэй ангилалд 73 ХЗХ багтсан бөгөөд эдгээр ХЗХ-дод авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан.

Эрсдэлийн үнэлгээний аргачлалыг турших ажил буюу нийт ХЗХ-дын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан мэдээлэл болон зайны хяналтын бусад мэдээлэлд тулгуурлан эрсдэлийн үнэлгээ хийсэн. Мөн 2019 оны эхний хагаст говийн бүсийн 15, Баян-Өлгий аймагт үйл ажиллагаа явуулж буй 12 ХЗХ-г үнэлэв.

Ийнхүү эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэхэд туслалцаа үзүүлэх чиглэлээр АХБ-ны төслийн хүрээнд нийт ХЗХ-дод бүсчилсэн байдлаар эрсдэлийн үнэлгээ хийж, түүнийг газар дээрх шалгалтаар бататгах, мөн тухайн бүсэд үйл ажиллагаа явуулдаг хоршоодын хяналтын зөвлөлийг чадавхжуулах, дотоод хяналтыг сайжруулах сургалтыг дээрх хөтөлбөрийн дагуу зохион байгуулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд 2019 оны 9 дүгээр сард төвийн болон хангайн бүсэд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

## БАЙР СУУРЬ – ЯРИЛЦЛАГА

# САНХҮҮГИЙН САЛБАРТ ИТГЭХ ИТГЭЛИЙГ БИЙ БОЛГОХ ЧУХАЛ ХӨШҮҮРЭГ НЬ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЮМ

*Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга  
Б.Долгорсүрэнтэй ярилцлаа.*

## – Хяналт шалгалт, зохицуулалтын газрын ажлыг уншигчдад танилцуулна уу, түүнийгээ хэрхэн хэрэгжүүлж байна вэ?

–Хяналт шалгалт гэдэг бол зохицуулалтын нэг хэлбэр юм. Бид төрийн зохицуулалт талаасаа, санхүүгийн салбарыг зохицуулж байгаа салбарын хууль болон тэдгээрт шилжүүлсэн дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангуулдаг. Хяналт шалгалт гэдэг нь Хорооны нүд, чих юм. Тиймээс нүд хурц, чих соргог байж тухайн салбарт юу болж, юу болохгүй байна, юуг бид эрсдэлтэй гэж харах вэ гэдэг нь бидний ажил. Энэ бүхнийг харж, хянаж шалгахын цаад гүнзгий утга нь санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах ёстой гэсэн зорилго дээр очдог. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд Хорооны үндсэн чиг үүргийн нэг нь санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах гэж заасан.

Хяналт шалгалт гэдгийг хүмүүс зөвхөн хянадаг, шалгадаг, торгодог гэж ойлгоод байдаг. Гэтэл энэ чинь төрийн өөрийнх нь хамгийн чухал зохицуулалт юм. Нэг ёсондоо санхүүгийн салбарт байгаа санхүүгийн мэргэжлийн байгууллагууд тодорхой хэмжээний төлбөрийн болоод хариуцлага хүлээх чадвартай, ажиллаж байгаа хүний нөөц нь ёс зүйтэй байх зэрэг нөхцөл шаардлагууд бий. Үүнийг төрийн зохицуулагч байгууллагууд хангуулж, шаардлага тавьж ажиллаж байна.

Санхүүгийн салбар өөрөө харилцан итгэлцэл дээр суурилдаг. Тэр итгэлцэл, санхүүгийн салбарт итгэх итгэлийг бий болгох чухал хөшүүрэг нь хяналт шалгалт юм. Бид тэнд байгаа зөрчлийг илрүүлж, засаж залруулдаг. Хууль зөрчсөн үйлдэл давтагдсан нөхцөлд арга хэмжээ авдаг, болохгүй бол тухайн

салбараас шахаж гаргадаг. Зөвхөн шахаж шаардаад гаргах биш зохицуулалтад байгаа санхүүгийн байгууллагуудаа тодорхой хэмжээнд дэмжиж, ижил боломж олгон ажилладаг.

## –СЗХ–ны Хяналт шалгалтын газрын үүсэл, түүх гэвэл?

–СЗХ 2006 онд анх бий болоход хяналт шалгалтын газрыг тусад нь байгуулсан. Тухайн үед санхүүгийн зах зээл дөнгөж бүрэлдэж байлаа. Банкнаас бусад санхүүгийн секторын хөгжлийн явц банкны системтэй харьцуулахад маш жижиг байсан. Даатгалын салбарын зохицуулалт Мэргэжлийн хяналтын газарт, үнэт цаасны зах зээлийн зохицуулалт нь Үнэт цаасны хороонд, ББСБ–уудын зохицуулалт нь банктайгаа хамт Монголбанкнд хамаарч, хадгаламж зээлийн хоршоо нь төрийн зохицуулалтад хамрагдаагүй байв. 2004–2006 оны эдийн засгийн хямралын дараа л төр ХЗХ–г зохицуулах ёстой гэдэг дээр анхаарсан. Тэгээд эдгээр байгууллагыг СЗХ–ны зохицуулалтад хамруулж байлаа.

2007–2008 оны үед эдийн засаг сайжирч, санхүүгийн зах зээл ч өргөжиж эхэлсэн. Энэ үеэс Хороо, салбар бүр рүү чиглэсэн хяналт шалгалт байх нь зүйтэй гэж үзээд хяналт шалгалт, бодлого зохицуулалт нэг дороо байхаар өөрчилж 2014 он хүртэл тэр бүтцээрээ явсан. 2014 оноос эдийн засгийн байдал өөрчлөгдөж, олон улсын эдийн засгийн нөхцөл байдал, дэлхийн санхүүгийн хямралууд, түүний давалгаа долгион манай орныг маш хүчтэй цохисон. Бас энэ үеэс Монгол Улсын санхүүгийн салбар олон улсын чиг хандлага дагаад интеграцчлагдах буюу хавтгайрсан нөхцөлд Хороо ч маш болгоомжтой ажиллаж

байсан ба болгоомжтой байна гэдэг нь зах зээлийг дэмжихгүй байна гэсэн үг биш бөгөөд аажимдаа Хорооны зохицуулалтын салбарууд хоорондоо уялдаж эхэлсэн. Тухайлбал ББСБ, даатгалын компаниуд үнэт цаасны зах зээл рүү орж ирж, олон нийтэд хувьцаагаа гаргах зэргээр санхүүгийн зах зээл глобалчлагдахын хэрээр хоорондоо уялдаж эхлээд байна. Тийм учраас хяналт шалгалт тухайн салбараа дагах биш, ерөнхий нэгдсэн шалгалтын систем явах ёстой болсон. Мөн банк толгойтой, дотор нь санхүүгийн байгууллагууд орчихсон нэгдлүүд, даатгалын компани, ББСБ–тай санхүүгийн группүүд бий болчихлоо. Энэ нэгдлүүдийг нэгдсэн журмаар, нэг цонхоор, нэг өнцгөөс харж зохицуулах нь оновчтой арга юм. Тийм учраас Хороо сүүлийн гурван жил Хяналт шалгалт, зохицуулалтын газрыг тусад нь байгуулан ажиллуулж байна.

## –Хянаж шалгах арга хэлбэр ч бас өөрчлөгдөж байна уу?

Олон жилийн практикаас харахад өмнө нь хяналт шалгалт хийдэг процесс их энгийн байсан. Гүйцэтгэлд суурилсан хяналт шалгалт явуулж, өнгөрсөн цаг үеийнх нь баримт материалд тулгуурлаж үнэлгээ өгдөг байлаа. Энэ бол үр дүн муутай арга байсан.

Хороо 2011 оноос эхлээд гүйцэтгэлд суурилсан хяналт шалгалтаас эрсдэлд суурилсан хяналт шалгалт руу шилжих бодлогыг баримтлан энэ хүрээнд тусгайлсан газар, нэгжүүд байгуулагдаж, хариуцсан чиглэлүүдээ аваад явж байна.

Олон улсын хяналт шалгалтын стандарт ч бас өөрчлөгдлөө. Жишээ нь БАЗЕЛ–ийн хороо банк, ББСБ, даатгалын байгууллагуудад хийх хяналт нь эрсдэлд суурилсан шалгалт байх ёстой гэдэг дээр тогтсон. Олон улсын байгууллагууд “Хяналт шалгалт нь оновчтой, чухам эрсдэлийг олж хардаг, ирээдүйд ирж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байх ёстой” гэсэн бодлогыг барьж байгаа. Бид ч эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд бүрэн шилжихээр ажиллаж байна.

Тухайлбал, даатгалын салбар дээр эрсдэлд суурилсан шалгалтыг туршилтын журмаар явуулаад жил гаруй болж байна. Мөн Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд ХЗХ–дын хандлагад чиглэсэн хяналт шалгалт буюу өнгөрсөн үүх түүхийнх нь хандлагыг нь хараад ирээдүйд гарч болох эрсдэлийг нь

хайдаг, олдог, түүнийг зохицуулдаг ажлыг эхлээд, туршаад явж байна. Үнэт цаасны зах зээл дээр тодорхой хэмжээний эрсдэлүүдийг хаах, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх эхний алхмуудыг хийлээ. Үнэт цаасны компаниуд нь төлбөрийн чадвартай байх ёстой, санхүүгийн боломжтой гэдэг үүднээс бид тэднийг чадавхжуулах чиглэлд нэлээн ажиллаж байна. Санхүүгийн тайлан мэдээллийн маягуудыг нь бүгдийг шинэчилсэн.

**–Технологийн хурдацтай хөгжил хяналт шалгалтын ажилд хэр нөлөөлж байна вэ?**

–Дэлхий нийтээрээ аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалын хувьсалд орж, бүх асуудлыг техник технологид суурилан шийддэг болчихсон энэ үед бид ч санхүүгийн салбарын хяналт, зохицуулалт нь технологид, инновацид суурилсан байх ёстой гэдэг рүү явж байгаа. Тэгээд програм хангамжуудаа аль болох төгөлдөршүүлэх, зохицуулалтыг илүү оновчтой, түргэн шуурхай болгохоор ажиллаж байна.

**–Ажилтнуудынхаа мэдлэг, чадварыг дээшлүүлэх тал дээр хэр ажиллаж байгаа вэ?**

–Эрсдэлд суурилсан хяналт шалгалт гэж яриад байгаагийн гол суурь, хэрэгжүүлэгч нь хүн юм. Тийм учраас Хороо Дэлхийн банктэй хамтраад нийт ажилтан, ялангуяа хянан шалгагч нарыг чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Бид зөв бодлого барьж, сайн хэрэгжүүлэхийн төлөө чармайн ажилладаг. Гэтэл хүний нөөцийн туршлага, ур чадвар дутуу бол ямар ч ажиллагаа нурж унана. Энэ бол хамгийн том эрсдэл. Бид эрсдэлийг гаднаас биш дотроосоо хайсан. Дотоод эрсдэл гэдэг нь хүмүүсийн ур чадвар, мөн бидний мөрдөж байгаа журам зааврын зөрчилдөөн, сул тал юм. Хороо дотоод журам, заавраа шинэчилж, хүмүүсээ чадваржуулж байна. Дараагийн алхам нь гадагшаа чиглэсэн, ББСБ, ХЗХ, даатгал, үнэт цаасны компаниуд гээд мэргэжлийн оролцогч байгууллагуудын ажиллагсад, ажилчдыг чадваржуулах явдал юм. Бид мэргэжлийн холбоодтойгоо хамтраад, зохицуулалтын байгууллагуудын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх сургалтыг тасралтгүй хийж байна. Энэ нь санхүүгийн зах зээл дэх хүний хүчин зүйлээс хамааралтай эрсдэлийг багасгахын тулд хийж буй ажил юм.

**–Сүүлийн жилүүдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг үйл ажиллагаа идэвхжлээ. Энэ чиглэлд ямар ажлууд хийж байна вэ?**

–Олон улсын хэмжээнд 2005 оноос мөнгө

угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг үйл ажиллагаа их идэвхжсэн. Монгол Улс энэ ажиллагаанд нэгдэж, 2006 онд хууль баталж, 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулж шинэчилсэн. Ингээд хяналт шалгалтын хүрээнд мөнгө угаах, терроризмтой тэмцэх ажлыг явуулахад Хороонд маш том үүрэг ноогдоод байна. Хороо өөрийн зохицуулалтын бүх байгууллагаас гадна үл хөдлөх хөрөнгө зуучлагч компаниуд, үл хөдлөх хөрөнгийн салбар дахь оролцогчдыг мөнгө угаах, терроризмтой тэмцэх чиглэлээр хянах болсон. Хорооны хяналт шалгалт, зохицуулалтын хүрээ улам л тэлж байна. Энэ ажлыг гүйцэтгэхэд нэгдсэн хяналт шалгалтын систем маань үр дүнгээ өгч байгаа. Зуучлалын компаниудын цаана нэг эзэнтэй, зэрэгцээ олон компаниуд байдаг, тийм байх магадлал өндөр. ББСБ–тай, банктэйгаа, үнэт цаасны компани, даатгалтайгаа хамт компаниуд бий болчихсон байна. Мөнгө угаах, терроризмтой тэмцэхтэй холбоотойгоор бид үүнийг хянах тухай асуудал яригдаж байна. Нөгөө талаасаа нэг хүндрэлтэй асуудал бол Монгол Улс өөрөө ФАТФ–ын саарал жагсаалтад орох эрсдэлтэй нөхцөл үүсчихээд байгаа. Бид одоо идэвхтэй хяналтанд явж байна. Түрүү жил ФАТФ–аас биднийг шалгах ёстой байсан боловч Монгол Улсын хийж байгаа хүчин чармайлтыг үнэлээд асуудлыг нэг жилээр хойшлуулсан. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг Монгол Улс, Хороо өөрийн хийх ёстой ажлуудыг бүгдийг нь хэрэгжүүлээд явж байгаа.

**–Хяналт шалгалтыг хэр давтамжтай явуулж, ямар арга хэмжээ авдаг вэ?**

Бид жил болгон төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтууд хийдэг. Хяналт шалгалтыг хоёр аргаар хэрэгжүүлдэг бөгөөд эхнийх нь зайнаас, нөгөөх нь газар дээр нь очиж шалгах шалгалт юм.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалт руу шилжиж байгаа нөхцөлд бид ихэвчлэн зайнаас хяналт тавих ёстой. Ингэхдээ тухайн байгууллагаас ирүүлж байгаа мэдээ нь хууль, хорооноос гаргасан журам заавраар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд, бусад дагаж мөрдөх хэм хэмжээг хангаж байгаа эсэх дээр улирал, сар болгон дүгнэлт гаргаж байгаа. Хэрэв тэр хэр хэмжээг хоёр, гурван улирал дараалан хангахгүй байвал тухайн байгууллага эрсдэл, доголдолд оржээ гэж харагддаг учраас газар дээр нь очиж шалгалт хийдэг. Зөрчил, доголдол илэрвэл бид дараагийн арга хэмжээг авч, тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх асуудал тавина. Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн

хуацаанд тэр байгууллага Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн нөхцөлд, өөрсдөд нь цаашид хэвийн үйл ажиллагаа явуулна гэсэн итгэл үнэмшил, байгууллагын удирдлагууд, хувьцаа эзэмшигч нарт нь доголдолгүй ажиллах чин эрмэлзлэл байгаа бол сэргээх асуудал яригддаг.

2017 оны долдугаар сарын 01–ний өдрөөс Монгол Улсад Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын ажлын ачаалал эрс нэмэгдсэн. Шинээр мөрдөж байгаа Зөрчлийн тухай хууль болон Зөрчлийн хэрэг хянан шалгах хуулиар гарсан бүх зөрчил дээр зөрчлийн хэрэг нээгдэж, зөрчлийн хэргээр дамжуулж шийтгэл оногдуулдаг болчихсон. Үүнтэй холбоотойгоор Хорооны хяналт шалгалтын ажлын цар хүрээ маш өргөжсөн. Энэ өөрөө маш том асуудал.

**–Энэ тухай тодруулж яриач?**

–Юуны өмнө ажлын ачаалал ихэсч, нэмэлт хүн хүч хэрэгтэй болсон. Давуу тал нь Зөрчлийн тухай хуулиар дамжаад санхүүгийн зах зээл дээрх сахилга бат, үр дүн сайжирсан. Аливаа зөрчлийн торгуулийн дүн нь өндөр боллоо. Зөрчлийн хэрэг нээгдээд шийдэгдэх хүртэл хэрэг бүртгэлийн ажиллагаа прокурорын хяналтан дор явдаг учраас хэн нэгэн хөндлөнгийн этгээд нөлөөлөх боломжгүй.

**–Цаашид хийхээр төлөвлөж буй ажлууд гэвэл?**

–Санхүүгийн зах зээлийн тэлэлт нь хяналт шалгалтын бодлого зохицуулалтыг нарийвчлах ёстой гэдэг асуудлыг харуулж байгаа. Урд нь цомхон, дангаараа үйл ажиллагаа явуулдаг байсан ББСБ–ууд технологид суурилсан компаниуд болж хувирч, үнэт цаасны зах зээл дээр гараад, олон нийтээс хөрөнгө татаж байна. Даатгалын салбар маань ч үнэт цаасны зах зээл рүү ороод ирсэн. Бас л технологид суурилсан үйлчилгээ, боломжийг санал болгож, олон нийтэд нээлттэй болж байна. Үнэт цаасны компаниуд ч технологи дагаад сайжрах ёстой. Бүх юм технологи болж буй энэ бүх өөрчлөлтийг дагаад эрсдэлүүд ч үүсээд эхэлж байгаа юм. Энэ бүгдийг даван туулахын тулд бид IT хянан шалгагч гэсэн шинэ мэргэжлийн хүмүүстэй байх хэрэгтэй. Бидэнд санхүүгийн салбараар мэргэшсэн хуульч нар маш их хэрэгтэй болж байна. Санхүүгийн салбарт нэгдэх, хамтрах явц түргэсэхээр маш хүчтэй багууд бий болж эхэллээ. Тэд хуулийн компаниуд, зөвлөхүүдтэй хамтран ажиллаж байна. Хийж байгаа шийдэл болгон нь

нухацтай, далайцтай явагдаж эхэллээ. Бид хуулийг тэднээс илүү мэдэхгүй бол үйл ажиллагаа нь хуульд нийцэж байгаа эсэхийг шалгахад асуудал үүснэ. Одоо урт удаан жил ажилласан гэдгээрээ туршлагаждаг асуудал үгүй болж байгаа учраас хүмүүсийнхээ хандлагыг өөрчлөх ёстой.

**–Санхүүгийн зах зээлийн тэлэлт салбар дээрээ байгаа хүмүүст маш хүчтэй мэдрэгдэж байгаа юм байна. Тийм үү?**

–Тэгэлгүй яах вэ. Өмнө бид үнэт цаасны салбарыг биржид бүртгэлтэй хэдэн брокер, диллерийн компани гэдгээр л боддог байсан. Гэтэл одоо тийм биш болчихлоо. Хөрөнгө оруулалтын сангууд, хөрөнгө оруулалт менежментийн компаниуд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаад эхэлчихлээ. Үнэт цаасны зах зээл маш эрчтэй задарч байна. Зах зээл хурдацтай хөгжиж буй нь бидний өмнө асар их хариуцлага, даалгаврыг бий болгож байна. Энэ бүгдийг бид цаг тухайд нь мэдэх, тэмтрээд мэдрэх ёстой, хараад таних ёстой. Тухайн салбарын хүмүүсээс илүү харж байж л бид бодлого зохицуулалт хийнэ.

**–Та бүхэн сайн ажиллахгүй бол жирийн иргэд хохирох магадлал их шүү дээ?**

–Энэ чинь л төрийн, Хорооны үндсэн хүлээсэн үүрэг юм. Бид санхүүгийн зах зээл дээр хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаална. Тэд нар л хамгийн эрсдэлгүй орчинд байх, хэрэглэгч хамгаалагдах ёстой. Нөгөө талдаа бид зохицуулалтын байгууллагуудаа дэмжиж, тэднийг чадваржуулах ёстой. Энэ бол дугаарлах боломжгүй нэг асуудлын хоёр тал шүү дээ.

СЗХ бүтэцдээ 2015 оноос хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр тусгай нэгжтэй болсон. Тэр нэгжээрээ дамжуулж зөвхөн өргөдөл гомдол хүлээж аваад шийдэх биш, хүмүүсийн гаргаж буй өргөдөл, гомдол дээр судалгаа хийж, яагаад, юунаас болж буй шалтгаан, суурийг нь олж хууль, журамд өөрчлөлт оруулах бэлтгэл ажлыг хийдэг. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудлын нөгөө талд олон нийтийн санхүүгийн боловсрол гэж чухал зүйл бий. Нэг талаас аливаа санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүн хамгийн бага зардлаар, хурдан шуурхай хэрэглэгчид очихыг л Хороо дэмжиж байгаа. Харин нөгөө талд нь энэ үйлчилгээг хүлээж авах чадвартай хэрэглэгч байх ёстой. Бид иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарах ётой. Тийм учраас бид “Та үнэт цаасны зах зээлд оролцох бол үүнийг анхаараарай, даатгуулахад таньд ийм

сонголт бий шүү, зээл авах болбол зээлийн гэрээний заалтуудыг хараарай, хүү, хураамж шимтгэлийн асуудал нь ийм шүү” гээд байнгын сургалт явуулж, зөвлөмж гаргаж байгаа.

**–Манайхан мэдээллийг нягтлахгүйгээр ашигтай гэж сохроор итгэн, санхүүгийн эрсдэлд ордог тал бий?**

–Хүмүүс зээл, үйлчилгээ авсныхаа дараа л маргаан хийдэг. Хэзээ ч эхлээд гэрээгээ уншдаггүй, сэтгэл хөдлөл, хэрэгцээндээ хөтлөгдөөд тодорхой үйлчилгээ авчихдаг. Энэ нь хүмүүсийн санхүүгийн боловсрол нимгэн байгаатай л холбоотой.

Иргэд санхүүгийн мэдлэг нимгэнээс гадна буруу сонголт их хийдэг. Жишээ нь манайд ирж буй өргөдөл гомдлуудын гол хэсэг нь жолоочийн албан журмын даатгалтай холбоотой байна. Даатгалын компани, даатгуулагч хоёрын хооронд гарсан маргаан нь ихэвчлэн нөхөн төлбөртэй холбоотой байдаг. Хороо өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд бүх маргааныг шийдвэрлэж байгаа. Даатгагч компани гэрээгээ дагаж мөрдөөгүй, эсвэл тодорхой бус баримтаар нөхөн төлбөр төлөхөөс татгалзсан нөхцөлд бид хугацаатай үүрэг даалгавар өгдөг. Энэ асуудал олон удаа давтагдвал “Компани эрсдэлтэй байна” гэж үзээд бид шалгадаг, анхааруулдаг. Хорооны хяналт шалгалт, зохицуулалтын тогтолцоо гэж бүхэл бүтэн систем ажиллаж байна шүү дээ.

**Танайх олон асуудал хариуцдаг, ачаалал ихтэй ажилладаг бололтой?**

–Зургаан салбарын асуудлыг хариуцан ажиллаж байна. Программ хангамжаа сайжруулаад технологийн өөрчлөлтөөс хоцрохгүй явж байна. Учир нь бид ерөөсөө хоцорч болохгүй. Зохицуулалтын байгууллагууд маань биднээс хэт түрүүлээд явчихвал, тэдний юу хийж байгааг ойлгохгүйгээр яаж хянах вэ дээ.

**–Танай хяналт шалгалтын газрын ажиллах хүрээ нэмэгдэнэ гэдэг нь санхүүгийн зах зээлийн үр ашиг хүмүүст сайн хүрч буйг илтгэж байна гэвэл болох уу?**

–Тийм ээ. Санхүүгийн хүртээмж нэмэгдэж байгаа. Хүмүүс зээл авах гэж банкин дээр очоод, материал нь гологдоод буцдаг байсан бол одоо гар утсаараа зээл авах боломж нээгдчихлээ. Дижитал даатгал, зээл гээд энэ бүх үйлчилгээ хэрэглэгч рүү маш хурдан, хямдхан, шударга очих ёстой. Шударга гэдэг нь зээл авсан, ямар нэг үйлчилгээ авсан хүн, тухайн байгууллагаас болж эрсдэлд орох ёсгүй гэсэн үг юм. Түүнийг л бид харж

хянаж байна. СЗХ төрийн байгууллагын хувьд хуулиар оноосон, өөрийнхөө хийж чадах бүр үйлдлийг хийж байгаа. Хорооны бодит боломжоос давсан, зээлийн хүүгийн асуудал, үнэт цаасны зах зээл дээр Хороо байгуулагдахаас өмнө зөвшөөрөлгүй зарагдсан хувьцаануудын маргаан, 1991 онд их хувьчлалаар бий болсон 475 компаниудын ихэнх нь алга болчихсон гэх мэт асуудлууд бий.

СЗХ–нд 2000 зохицуулалтын байгууллагыг хянах гэж 100 гаруй хүн ажилладаг. Хяналт шалгалтын газар 30 хүнтэй. Бид бүх хүчээ төлөвлөж, боломжоо дайчлан ажиллаж байна.

## ТАЙЛБАР – ЗӨВЛӨМЖ

### ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД ХҮРГЭХ НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖ

#### Нийтлэг зүйл

Санхүүгийн хэрэглэгч зарим тохиолдолд санхүүгийн гэрээний нөхцлүүдтэй танилцаж, бүрэн гүйцэд таних боломжгүй байдаг. Тусгай зөвшөөрөл бүхий санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч тухайн хэрэглэгчид шийдвэр гаргахад нь шаардлагатай, үнэн зөв мэдээллээр хангах үүрэгтэй тул дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Санхүүгийн аливаа үйл ажиллагаа нь хоёр талт гэрээний харилцаагаар зохицуулагддаг тул үйлчлүүлэгчид гэрээ болон түүний хавсралтад заасан нөхцлүүдтэй сайн танилцахгүйгээр санхүүгийн гэрээг байгуулахгүй, санхүүгийн байгууллагын ажилтнаас уг гэрээтэй дэлгэрэнгүй танилцах боломж олгохыг хүсэх;
- Гэрээний нэгдсэн загварт баригдалгүйгээр өөрт тань тохирох тусгайлсан нөхцлийг санал болгож, харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээ байгуулах;
- Санхүүгийн үйлчилгээний гэрээг баталгаажуулсны дараа уг гэрээнд заасан өөрийн хүлээх үүргийг хариуцлагатайгаар мөрдөж, биелүүлэх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, санхүүгийн гэрээний маргаантай асуудал үүссэн тохиолдолд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын холбогдох ажилтанд хандаж, шийдвэрлүүлэх, уг шийдвэрийг эс зөвшөөрвөл Санхүүгийн зохицуулах хороонд хандан зөвлөгөө авах, шаардлагатай гэж үзвэл маягтын дагуу өргөдөл гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд хандан урьдчилан шийдвэрлүүлэх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбоотой маргаантай асуудлаар гарсан тус Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах;
- Хэрэв маргаантай асуудлаар гаргасан

шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах.

#### Даатгуулагч

- Даатгалын гэрээ, хураамж төлсөн болон нөхөн төлбөртэй холбоотой холбогдох баримтуудыг хадгалах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбогдох маргааныг Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд хандан урьдчилан шийдвэрлүүлэх ба тус Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах.

#### Банк бус санхүүгийн байгууллагын харилцагч

- Зээл олгогч бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн санал болгож буй гэрээний нөхцлүүдтэй харьцуулж, зээлийн дүн, хүү, алданги, зээлийн эргэн төлөлтийн хуваарьтай танилцсаны эцэст сонголт хийж, шийдвэрээ гаргах;
- Зээлийн даатгал нь албан журмын даатгалын төрөлд хамаарахгүй бөгөөд зөвхөн санхүүгийн хэрэглэгчийн зөвшөөрлийн үндсэн дээр байгуулахыг анхаарах;
- Зээлийн гэрээ, төлбөр төлсөн баримтуудыг хадгалах;
- Зээлийн гэрээг дуусгавар болгосон тохиолдолд зээлдүүлэгчээс гэрээний үүргийн гүйцэтгэл хангагдсан талаарх тодорхойлолт авч, Зээлийн мэдээллийн сан болон Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн байгууллагад шаардлагатай бүртгэлийг хийлгэх;
- Зээлийн гэрээнд санхүүгийн байгууллагын зүгээс санхүүгийн хэрэглэгчид мэдэгдэлгүйгээр дангаараа гэрээг цуцлах, гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах зэргээр санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хөндсөн эсэхийг анхаарах;
- Хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийн үлдэгдэлд тооцох нэмэгдүүлсэн хүүг үндсэн хүүгийн 20 хувиас хэтрэхгүй

тооцохыг Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулиар зохицуулсан байгааг анхаарах.

#### Хөрөнгө оруулагч

Юуны өмнө та “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигч эзэмшигч эсэх, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид данс нээсэн эсэхээ [www.schcd.mn](http://www.schcd.mn) цахим хуудаст зочилж, мэдээлэл авах, хэрэв данстай бол өөрийн харилцагч үнэт цаасны компани дээр очих, эсхүл “**Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв**” ХХК /Хаяг: Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Самбуугийн гудамж 16/1, Утас: 7012-0460/-д иргэний үнэмлэхтэйгээ очин харилцагчийн дэлгэрэнгүй хуулгыг төлбөртэйгөөр гаргуулан авах;

- Холбогдох баримтуудыг хадгалах;
- Хувьцааг нь эзэмшиж буй компанийн үйл хэрэгт /хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн гишүүдийг сонгох/ идэвхтэй оролцох;
- Төвлөрсөн хадгаламжийн данс дахь үнэт цаас, бэлэн мөнгөний үлдэгдэлд тогтмол хяналт тавих, шаардлагатай гэж үзвэл тодорхой хугацаанд дансны гүйлгээг царцаах;
- Өөрийн хэрэгцээ, шаардлагыг хангасан гэж үзсэн үнэт цаасны компанийг сонгон үйлчлүүлэх.

#### ДААТГУУЛАГЧИД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

##### Даатгал ...

Хүмүүний амьдралын хэвийн үйл явцыг алдагдуулдаг байгалийн гамшиг, осол аюул, гал түймэр, газар хөдлөлт, дээрэм тонуул зэрэг урьдчилан тооцоолох боломжгүй, гэнэтийн шинжтэй эрсдэлийг бууруулах, учрах тохиолдолд хохирлыг нөхөх санхүүгийн үр дүнтэй арга нь даатгал.

**Даатгалын үндсэн ухагдахуун**

№	Нэр томъёо	Утга
1	Даатгал	Ирээдүйд учирч болох эрсдэлийг шилжүүлэх, бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа
2	Даатгалын зүйл	Даатгалд хамрагдсан эд хөрөнгө, хариуцлага, амь нас, эрүүл мэнд, орлого
3	Даатгалын гэрээ	Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх даатгалын харилцааг зохицуулсан эрх зүйн баримт
4	Үнэлгээ	Даатгалын зүйлийг үнэлж, даатгуулсан мөнгөн дүн
5	Даатгалын тохиолдол	Даатгуулсан зүйлд хохирол учрах, даатгалын гэрээнд тохиролцсон болзол бүрдэх үйл явц
6	Даатгалын хураамж	Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөр
7	Даатгалын нөхөн төлбөр	Гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө
8	Даатгалын хугацаа	Даатгалын гэрээний хүчинтэй хугацаа

**Даатгалын харилцаа**

Даатгалын гэрээний үндсэн дээр нэг талаас даатгуулагч өөрийн эд хөрөнгө, ашиг сонирхлоо болзошгүй аюул, эрсдэлээс учирч болох хохирлоо нөхөх баталгаатай байхын төлөө зохих хураамж төлөх, нөгөө талаас даатгагч нь даатгуулагчид учирч болох хохирлыг бүрэн буюу зарим хэсгийг төлөхөөр үүрэг хүлээж, эрх эдлэх тохиролцсон харилцаа юм.

Даатгалын харилцаанд даатгуулагч, даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч, зохицуулагч байгууллага оролцдог.

№	Нэр	Тодорхойлолт	Үйл ажиллагаа
1	Даатгуулагч	Өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээд	Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгө, эдийн бус хөрөнгөө даатгуулна
2	Даатгагч	Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага	Ердийн 15, урт хугацааны даатгалын 1, 255 салбар
3	Даатгалын төлөөлөгч	Даатгагчийн нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн үйлдэл хийхээр томилсон, эрх олгосон этгээд	Тусгай зөвшөөрөл бүхий 3340 даатгалын төлөөлөгч
4	Даатгалын зуучлагч	Бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө хэлцэл хийх этгээдтэй холбох этгээд	Тусгай зөвшөөрөл бүхий 37 даатгалын зуучлагч
5	Даатгалын хохирол үнэлэгч	Даатгалын тохиолдлоор үүссэн бодит хохирлыг хараат бусаар тогтоох үүрэг бүхий этгээд	Тусгай зөвшөөрөл бүхий 27 даатгалын хохирол үнэлэгч
6	Зохицуулагч	Даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хянах Санхүүгийн зохицуулах хороо	Даатгалын үйл ажиллагаатай холбоотой маргааныг урьдчилан шийдвэрлэнэ

**Даатгуулагчид ямар эрсдэл үүсч болох вэ?**

- даатгалын бүтээгдэхүүнийг оновчгүй сонгосноор үр ашиггүй зардал гаргах
- бага хамгаалалтанд өндөр хураамж төлөх
- даатгалын гэрээний эрх, үүргээ биелүүлээгүйгээс нөхөн төлбөр авах эрхээ алдах

**Даатгуулагчийн эрсдэлийн шалтгаан ...**

- даатгалын талаар мэдлэг, туршлага бага
- өөрийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлага, хандлагыг оновчтой тодорхойлоогүй
- даатгалын гэрээний нөхцөлүүдтэй бүрэн танилцаагүй

**Даатгалын бүтээгдэхүүнийг сонгох ...**



**Танд ямар даатгал хэрэгтэй вэ?**

Танд хэд хэдэн төрлийн даатгал хэрэгтэй байж болно.

Гэхдээ хүн бүрт бүх төрлийн даатгал хэрэгтэй гэсэн үг биш бөгөөд ямар даатгалд хамрагдах нь таны хэрэгцээ шаардлага, нөхцөл байдал, хандлагаас хамаарна.

Даатгалд хамрагдах шаардлагатай эсэхээ шийдэхийн тулд даатгалын зардлыг даатгалгүйн улмаас учирч болох хохирлын хэмжээтэй харьцуулан дараах асуултыг тунгаан бодоорой. Үүнд:

- болзошгүй эрсдэл ...
- Амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвараа алдах (даатгалын тохиолдлоос үүсэх санхүүгийн үр дагаврыг шийдэх), хулгай, дээрэмд өртөх, байгалийн гэнэтийн үзэгдэл, гал түймэр, гэнэтийн ослын улмаас эд хөрөнгө тань эвдэрч гэмтэх гэх мэт.
- эрсдэл учрах магадлал, хэрэв эрсдэл учирвал ...

Ойрын ирээдүйд амь нас, хөдөлмөрийн чадвараа алдах эрсдэл бага боловч хэрэв та гэр бүлийнхээ гол тэжээгч бөгөөд даатгалын тохиолдол үүсвэл таны гэр бүлд санхүүгийн хүндрэл учрах уу? Мөн таны орон гэр галд өртөх эрсдэл бага байж болох ч хэрэв галын аюул тохиолдвол үүсэх хохирол асар их.

Таны машин эвдэрч гэмтэх, хулгайлагдах эрсдэл харьцангуй өндөр байх ч үүнээс үүсэх хохирол нь орон гэрээ алдсаны улмаас учрах хохирлоос ихгүй байх бизээ.

Хэрэв дээр дурдсан эрсдэлийн аль нэг нь тохиолдоход та болон таны гэр бүл хохирлыг төлөх чадваргүй бол даатгалд хамрагдах талаар бодолцох нь зүйтэй.

**Харьцуулалт хийх**

Даатгалын гэрээ байгуулахаасаа өмнө даатгалын компаниудын санал болгож буй даатгалын хамгаалалт, даатгалын хураамж, нөхөн төлбөртэй холбоотой гэрээний нөхцөлүүдийг харьцуулж үзээрэй.

Хамгийн бага үнийн санал, тэрээр хамгийн боломжтой санал байдаггүй гэдгийг санаарай. Жишээ нь, цөөхөн төрлийн эрсдэлийг даатгаж буй, эсвэл даатгалын төлөх нөхөн төлбөрийн хувь хэмжээ бага учраас хураамж нь бага байж болно.

Даатгалын гэрээнд таны хүссэн бүх эрсдэлээс хамгаалах нөхцөл тусгагдсан эсэхийг та сайтар судалж баталгаажуулаарай.

## Даатгалын гэрээтэй дэлгэрэнгүй танилцах

Даатгалын гэрээний нөхцөлүүдтэй анхааралтай танилцахад өөртөө хугацаа зарцуулж, тодорхой бус зүйл болон нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлүүдийг даатгалын ажилтнаас тайлбарлаж өгөхийг хүсээрэй. Даатгалын гэрээний нөхцөлийг бүрэн ойлгож, хүлээн зөвшөөрөхөөс өмнө даатгалын гэрээнд гарын үсэг зурах, хураамж төлж хэрэггүй.

## Хариуцлагатай байх

Даатгагчаас шаардсан ямар нэг чухал мэдээллийг хэлэлгүй орхигдуулах, эсвэл худал мэдээлэл өгвөл даатгалын компани таны даатгалын гэрээг цуцалж, даатгалын нөхөн төлбөрийг төлөхөөс татгалзаж болно. Мөн даатгалын гэрээ, хураамж төлсөн болон нөхөн төлбөртэй холбоотой бүхий л баримтуудыг хадгалах шаардлагатай.

## Даатгалын нөхөн төлбөрийг нэхэмжлэх

Хэрэв даатгалын гэрээгээр даатгуулсан зүйлд учирсан эрсдэлийн улмаас танд хохирол учирсан бол та нэн даруй даатгалын компани, хулгай, зам тээврийн осол, гал гарсан тохиолдолд эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдээрэй.

Даатгалын байгууллагад нэхэмжлэл гаргахад эрх бүхий байгууллагын дүгнэлт, тодорхойлолт, ослын улмаас эвдэрч гэмтсэн эд хөрөнгийн зургийг нэн даруй авч баримтжуулан хулгайн тохиолдол бол хулгайлагдсан зүйлсийн жагсаалт, холбогдох төлбөрийн баримтуудын бүрдлийг хангаж, маягтын дагуу нэхэмжлэлийг гаргана.

Баримт нотолгоо, мэдээлэл их байхын хэрээр хурдан хугацаанд даатгалын компаниас нөхөн төлбөрөө авах юм.

## Санхүүгийн зохицуулах хороонд хандах

- Хорооны цахим хуудсанд хандах
- Холбогдох ажилтнаас утсаар зөвлөгөө авах, ирж уулзах
- маргаантай асуудлаар өргөдөл, гомдол бичгээр гаргах

## Даатгалын гэрээний маргаан

Хэрэв даатгалын гэрээний маргаан үүссэн тохиолдолд даатгагчид хандах ба даатгагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө Санхүүгийн зохицуулах хороонд хандаж урьдчилан шийдвэрлүүлнэ.

## Өргөдөл гаргахад анхаарах зүйлс

Та даатгалын гэрээний маргаантай холбоотойгоор өргөдөл гомдол, санал хүсэлт гаргахдаа дараах баримтыг хавсаргана.

- иргэний үнэмлэхний хуулбар
- даатгалын гэрээ
- тухайн даатгалын тохиолдолд хамаарах бичиг баримт (эрх бүхий байгууллагын дүгнэлт, тодорхойлолт, хохирол үнэлгээний тайлан болон бусад нотлох баримт)

Таны гаргасан өргөдөл, гомдлыг Санхүүгийн зохицуулах хороо хүлээн авснаас хойш холбогдох баримтад үндэслэн хуулийн хугацаанд хянан шийдвэрлэнэ.

Хэрэв тус Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах боломжтой юм.

## ББСБ-ЫН ЗЭЭЛДЭГЧИД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

**Банк бус санхүүгийн байгууллагатай зээлийн гэрээ байгуулан зээл авч буй хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нь**

Тус Хороонд ирүүлж буй ББСБ-тай холбоотой өргөдөл гомдлын дийлэнх олонхи нь гэрээний маргаан байдаг ба зээлдэгч нар хууль эрх зүйн мэдлэг хомс тул зээлийн гэрээтэй уншиж танилцахгүй шууд гарын үсэг зурж баталгаажуулсанаар дээрх маргаан үүсдэг.

Тус Хороонд ирүүлж буй ББСБ-тай холбоотой өргөдөл гомдлын дийлэнх олонхи нь гэрээний маргаан байдаг ба зээлдэгч нар хууль эрх зүйн мэдлэг хомс тул зээлийн гэрээтэй уншиж танилцахгүй шууд гарын үсэг зурж баталгаажуулсанаар дээрх маргаан үүсдэг.

Иймд зээл авахаар хүсч буй иргэнд зээлийн гэрээ байгуулахад анхаарч харах дараах хуулийн зүйл заалтуудыг сануулах шаардлагатай байна.

1. Зээлийн гэрээ нь 2 талын санаачилгаар харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулагддаг тул нэгэнт гарын үсэг зурж хүчин төгөлдөр болсон зээлийн гэрээнд зөвхөн гэрээний талууд нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой. Иймд гэрээний аль нэг хэсгийг өөрчлөлт оруулахаар СЗХ-нд гомдол гаргаад шийдвэрлэгдэх боломжгүй асуудал юм.
2. Зээлийн хүүний хэмжээг хуулиар зохицуулсан зохицуулалт байдаггүй тул

иргэн та зээл авахдаа зээлдүүлэгчийн тавьж буй зээлийн хүүний хэмжээг анхаарч адил үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудтай харьцуулан сонголтоо хийх.

3. Өөрийн нэр дээр зээлийн гэрээ байгуулж гарын үсэг зуран бусдад зээл авч өгөхгүй байхыг анхааруулж байна. Учир нь ийм үед таныг үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөх хуулийн зохицуулалт байдаггүй тул та зээлийн гэрээний нэг тал болж гарын үсэг зурснаар зээл төлөхөөс аргагүй байдалд хүрнэ.
4. Иргэний хуулийн 452.2."Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн төлөөгүй бол гэрээнд заасны дагуу зээлдүүлэгчийн үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр гэрээнд зааж болно. *Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлд анзыг хэрэглэхгүй.*" гэж заасан байдаг ч зарим ББСБ-ийн зээлийн гэрээнд үндсэн зээл болон хүүгээ төлөхгүй хугацаа хэтэрсэн тохиолдолд анз, алдангийг тооцож авахаар заасан байдаг ба энэ нь хууль зөрчиж байгаа тул ийм гэрээнд гарын үсэг зурахгүй байх, нэгэнт гарын үсэг зурсан бол анзын аль нэг хэлбэрийг төлөхгүй байх, эсхүл тус Хороонд мэдэгдэх,
5. Иргэний хуулийн 453.1."Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй."

Үүргийн гүйцэтгэлийг хангуулах хэлбэр нь нэмэгдүүлсэн хүү байх бөгөөд энэ нь зөвхөн зээлдэгчийн байгуулсан зээлийн гэрээний хугацаа дууссанаас эхэлж төлөгдөөгүй үлдсэн үндсэн зээлээс тооцож авдаг тул зээлээ хугацаандаа төлж байгаа зээлдэгчдэд хамаарахгүй ойлголт юм.

6. Зээлийн мэдээллийн сангийн тухай хууль болон "ББСБ-ийн активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам" –ын талаар тодорхой мэдээлэлтэй байх, Учир нь нэгэнт зээлийн гэрээнд гарын үсэг зурж зээл авсанаар үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас хэтрэхэд таны мэдээлэл Монголбанкны зээлийн мэдээллийн санд ордог. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Сангийн сайдын хамтарсан 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн тушаалаар батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам" –тай та доорх холбоосоор орж танилцана уу.

<http://www.frc.mn/djza/id/4866>

2011 онд батлагдсан Зээлийн мэдээллийн сангийн тухай хуультай дараах холбоосоор орж танилцана уу.

<http://www.legalinfo.mn/law/details/9175?lawid=9175>

# СУДЛААЧИЙН ИНДЭР – СУДАЛГААНЫ БҮТЭЭЛ

## АМЬДРАЛЫН ДААТГАЛ ЭДИЙН ЗАСАГТ

Өнөөгийн Монгол улсын эдийн засгийн байдал уул уурхай, дэд бүтэц зэрэг салбарын томоохон төслүүд амжилттай хэрэгжих эсэхээс хамаарч байна. Хэдэн тэрбум доллараар хэмжигдэх эдгээр төслүүдийг Чингис, Самурай бондоор санхүүжүүлэх боломжтой байсан ч төсвийн алдагдлыг нөхөх чиглэл рүү хазайгаад эхллээ. Үүнээс харахад Монгол улсын эдийн засаг гадаадын хөрөнгө оруулагчдаас ихээхэн хамааралтай болжээ. Монголчууд алс газар хөтөлгөө морьтой гардгийн адил бидэнд олон тулгуурт эдийн засгийн бодлого дутагдаж байна.

Дотоодын санхүүгийн эх үүсвэрийг идэвхтэй бий болгож үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжих замаар гадаад валютын хамаарлыг бууруулдаг туршлага олон улсын жишигт бий. Үүний тулд иргэд хуримтлалтай болж, түүнийгээ ашигтай хөрөнгө оруулалт болгох улмаар тэрхүү хөрөнгө оруулалт нь үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих тогтолцоог төрөөс бий болгодог байна.

Урт хугацааны хөрөнгө оруулалт шаардлагатай төслүүдэд урт хугацааны санхүүгийн эх үүсвэр, богино хугацааны төслүүдэд богино хугацааны санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй байдаг.

Өөрөөр хэлбэл эх үүсвэр болон хөрөнгө оруулалтын хугацаа ижил байх хэрэгтэй гэсэн шаардлага бий. Өөр хугацаатай эх үүсвэрүүдийг хооронд нь уялдуулж болох хэдий ч өртгийг өндөр болгох дутагдалтай талтай. Монгол Улсын хувьд урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр хангалттай алга байна.

Хөрөнгө босгохын тулд заавал өр тавихгүйгээр дотоодын хөрөнгө оруулагчдад эрх зүйн орчинг нь бүрдүүлж, айлаас эрхээр авдраа уухаа боломж бий.

эрх зүйн таатай орчин шаардлагатай.

Хөгжингүй орнуудад татварын уян хатан бодлого, тодорхой системийн зохицуулалтаар үүнийг шийдвэрлэдэг.

Эдгээрээс амьдралын даатгалаар дамжуулан эдийн засагт дэмжлэг үзүүлдэг практик байдаг.

### АМЬДРАЛЫН ДААТГАЛД ХЭН ДААТГУУЛАХ ВЭ?

#### АМЬДРАЛЫН ДААТГАЛ

<b>УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН САН ҮҮСГЭХ АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН БҮТЭЦ ДЭХЛЭГ</b>	<b>ТЭТЭВРИЙН ДААТГАЛ</b> ДААТГАЛ НИЙГЭМНИЙ ДААТГАЛАС ГЭВНИ ИХЭМЖИГТ ТЭТЭВЭР АВАХЫГ ХҮССЭН ХҮМҮҮС ДААТГУУЛНА	<b>ДААТГУУЛАГЧ</b> Хэдий хэмжээний тэтгэврийг ямар хугацаанд авахаа өөрөө сонгодог
<b>ХҮРИМТЛАЛЫН ДААТГАЛ</b> АМЬ НАСНЫ ДААТГАЛЫН ХАМГААЛАЛТАЙГААР <b>МӨНГӨН ХҮРИМТЛАЛ ҮҮСЭ</b>	2013, 2014, 2015, 2016	Амь насны даатгалын хангивалт гэдэг нь Хэрвэ даатгуулагч амь насна эхлээд даатгалын байгууллага АНХ ТӨХИРОЛДСОН МӨНГӨН
<b>ЭЦЭГ ЭХИЙН</b> АМЬ НАСНЫ ДААТГАЛЫН НИЙГЭМНИЙГ ХҮРИМТЛИЙД	КОЛЛЕКТИВНИЙ ХУМАНГАЛЫН ДААТГАЛ ИТ ТУЛГАМЖААД, САЛБИРЧИН ДААТГАЛТЭГЭЭР ХҮҮДИЙН ИИ ЭЗЭЛ СУУЧИЛЖИЙ ТӨСӨВНИЙ	Эцэг эхийн амь насны даатгалын хангивалт гэдэг нь Хэрвэ хүүхдийн эцэг эх амь насна аяваха үүсэсн хугацааны даатгалын туршицаг даатгалын байгууллагаас зарилдаг АНХ ТӨХИРОЛДСОН СУРГАЛТЫН ТӨВӨРӨЙГ БҮНЭЭР НЬ ХҮҮХДЭД ОЛГОХ НӨЛӨӨ
<b>АМЬ НАСНЫ ДААТГАЛ</b>	ЭРСДЭЛ ТӨХИРОЛДСОН ҮЕД ӨРХИЙН ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРИЙГ ТАСАЛДАХААС ХАМГААЛНА.	

### УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН САН ҮҮСЭ

УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН САН НЬ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР БОЛДОГ

УРТ ХУГАЦААНЫ ХУРИМТЛАЛЫН САН НЬ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР БОЛДОГ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД  
КОМПАНИЙН БОНД ХУВЬЦАА

### ЭДИЙН ЗАСАГТ

АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Хувьцаа эзэмшигчид → Даатгалын компаниуд → Хөрөнгийн зах зээл → Засгийн газар дэд бүтцийг байгуулах хөрөнгөтэй болно → ДНБ / GDP нэмэгдэж эдийн засаг өснө → Дотоодын хэргээс нэмэгдэнэ → Хөдөлмөр эрхлэлт дэвшилнэ → Инфляци буурна → Экспорт нэмэгдэж импортын эзлэлт багасна. Төлбөрийн тэнцэл байгичир дотоодын нийгмийн ханга чангарна → Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэнэ

Даатгал, хуримтлал, хөрөнгө оруулалтын урсгалууд  
Эдийн засагт үзүүлэх нөлөөллийн урсгал

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ НЬ: ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТОМ ХЭМЖЭЭНИЙ ТӨСЛҮҮД БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИХ УРТ ХУГАЦААНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ САНХҮҮЖҮҮЛДЭГ

<b>ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТОМ ХЭМЖЭЭНИЙ ТӨСЛҮҮД</b>	ДЭД БҮТЭЦ /ЗАМ ГҮҮР, ТӨМӨР ЗАМ БАРИХ	<b>ХУВИЙН ХЭВШЛИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	УУР УУРХАЙ
	НИЙГЭМНИЙ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ /ЭРҮҮЛ МЭНД БОЛОВСГОЛ		ҮЙЛДВЭР БАРИХ
	ЦАХИЛГААН СТАНЦ		ШИНЭ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
	ИПОТЕКИЙН ЗЭЭЛ		БИЗНЕСЭЭ ӨРГӨЖҮҮЛЭХ

### УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН САНГААР ДАМЖУУЛАН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ САНХҮҮЖҮҮЛСНЭЭР ЭДИЙН ЗАСАГТ БИЙ БОЛОХ ЭБЭРГ НӨЛӨӨ

- Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэнэ
- Экспорт өснө
- Бага хүүтэй, урт хугацаатай эзэлийн эх үүсвэр бий болно
- Мөнгөний ханш чангарна
- Байнгын ажлын байрны тоо нэмэгдэнэ
- Инфляци буурна

Эдийн засагт гарч буй эбэрг нөлөөллийн үр дүнд иргэдийн амьжиргааг түвшин дэвшилт даатгуулах сонирхол нэмэгдэнэ → даатгуулагчдын тоо нэмэгдэнээр урт хугацааны даатгалын сангийн хэмжээ өсж, хөрөнгө оруулалтын болгож нэмэгдэнэ

Үр ашигтай төлөвлөлт хийх замаар хуримтлал бий болгож, түүнийгээ эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд төрийн зөв бодлого, хууль

Амьдралын даатгалын компаниуд иргэдийн хуримтлалыг ашигтай нөхцөл санал болгох замаар өөртөө татан төвлөрүүлж, ирээдүйтэй төслүүдэд хөрөнгө оруулалт хийдэг.

Тухайлбал, даатгуулагчдынхаа өтөл насны амьдралын баталгааг хангах амлалт өгч тэтгэврийн сан байгуулж, ашигтай хөрөнгө оруулалтыг бий болгодог байна. Эдгээр даатгалын сангуудыг нарийн боловсруулсан хуулиар зохицуулж, тогтвортой ажиллуулах үүргийг төр хүлээдэг.

Мөн иргэдийн идэвх санаачилгыг нэмэгдүүлэхийн тулд даатгалын хураамжид татварын хөнгөлөлт үзүүлэх, даатгалд хамрагдаж байгаа хүмүүст урамшуулал олгох зэрэг ажлуудыг бодлого боловсруулагчдын зүгээс санаачлан ажилладаг байна.

Монгол улсад дээрх системийг нэвтрүүлсэн тохиолдолд нийгэмд тулгамдаад буй тэтгэвэр, эрүүл мэндийн асуудал болон

урт хугацааны хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг шийдвэрлэх боломжтой. Тэтгэвэр, хуримтлал, амь насны даатгалын сангууд нь өргөн хүрээний судалгаа, актуарын шинжлэх ухаан дээр үндэслэгдэж, урт хугацааны турш хуримтлагддаг.

Тиймээс энэ төрлийн бизнесийг төрийн зүгээс хууль эрх зүй, бодлого зохицуулалтаар ханган ажиллаж хөрөнгийн зах зээлд шууд бусаар дэмжлэг үзүүлдэг байна.

### АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН ЭДИЙН ЗАСАГТ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГҮҮД



## ӨРГӨН ДУРАН – СУРВАЛЖЛАГА

### Санхүүгийн салбарын комплаенс хэлэлцүүлэг 2019

Санхүүгийн зохицуулах хороо “Санхүүгийн салбарын комплаенс хэлэлцүүлэг– 2019”-ийг амжилттай зохион явуулав.

Хэлэлцүүлэг “Бизнесийн ёс зүй ба комплаенс”, “Комплаенс ба мөнгө угаах, терроризмыг

санхүүжүүлэх гэмт хэрэг” гэсэн хоёр хэсэгтэй. Энэ үеэр оролцогчид “Санхүүгийн салбарын ёс зүй болон комплаенсын өнөөгийн байдал”, “Бизнесийн ёс зүй комплаенсын үндэс болох нь”, “Санхүүгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа”, “Олон улсын санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллага (FATF)-ын Ази номхон далайн бүс нутаг хариуцсан бүлгээс (APG) өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын явц” зэрэг олон сонирхолтой илтгэлийг хэлэлцүүлээ.



Арга хэмжээг нээж СЗХ-ны дарга, доктор С.Даваасүрэн үг хэлэв. Мөн Азийн сангийн суурин төлөөлөгч Mark Koenig, СЗХ-ны Ажлын албаны дарга Б.Ариунаа, Захиргаа удирдлагын газрын дарга Б.Батзориг болон Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны дарга Х.Батчулуун, Азийн сангийн засаглалын хөтөлбөрийн менежер А.Баянмөнх нар илтгэл тавьж, оролцогчдын санал бодлыг сонсож, чөлөөт ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлэв.

“Санхүүгийн салбарын комплаенс хэлэлцүүлэг–2019”-д Азийн сан, Монголбанк, Сангийн яам, ГХЯ, ХЗДХЯ, ТЕГ, ОУВС, Дэлхийн банк, АХБ, ЕСБХБ, Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын ББСБ-уудын холбоо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо, Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын нэгдсэн холбоо, Монголын банкны холбоо зэрэг олон газрын төлөөлөгч оролцож санал солилцлоо.

## ХЭРЭГЛЭГЧ – ТАНИЛЦУУЛГА

### Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрхийн хамгааллын өнөөгийн байдал:

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах хуульд заасан үндсэн чиг үүргийн хүрээнд банкнаас бусад санхүүгийн зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд 17 хууль, 152 журмын дагуу хяналт шалгалт, зохицуулалтыг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын санхүүгийн зах зээлийн тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооноос баримталж буй санхүүгийн зах зээлийн хөгжил, шинэчлэлийн бодлогын хүрээнд санхүүгийн зах зээл, түүнд оролцогчдын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Хяналт шалгалт, зохицуулалтын газрыг бүтцэд бий болгоод байна.

Тус газрыг бие даасан хараат бусаар байгуулсан нь гүйцэтгэлд суурилсан хяналт шалгалтын хэлбэр, тогтолцоог халж, санхүүгийн зах зээл дэх эрсдэлийн төвшинг тооцоолох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэгдсэн эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх, зайны болон газар дээрх хяналт шалгалтын олон улсын стандартад тулгуурласан аргачлалыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ юм.

Улмаар хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд хамгаалах, хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах нэгжийг тус газрын бүтэц, үйл ажиллагааны чиглэлд бий болгоод байна.

Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институтийг бэхжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчид, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр 2016–2021”-ийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд дэлхийн хөгжлийн чиг хандлага, олон улсын туршлага төдийгүй өөрийн орны онцлог байдал, хүн амын санхүүгийн мэдлэгийн төвшинг харгалзан сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох, залуу үед санхүүгийн мэдлэг олгох, хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох, цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох чиглэлүүдээр түгээж байна.

Уг хөтөлбөрийн үр дүнд иргэдийн санхүүгийн сахилга бат сайжирч, санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадвар дээшлэн урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, санхүүгийн зах зээлд итгэх олон нийтийн итгэл дээшлэх юм.

Мөн Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны

тогтвортой өсөлтийг хангах үүднээс “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг Сангийн яам, Монголбанк, Хороо хамтран боловсруулж, Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор батлуулаад байна.

### Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалахад тулгарч буй хүндрэл бэрхшээл:

Хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах үр дүнтэй тогтолцоо бүрдээгүй, нөгөө талаас олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжих шатандаа байгаа, санхүүгийн мэдлэг дутмагаас өөрсдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах тухай ойлголт иргэдийн дунд хангалтгүй байгаа нь бэрхшээлийг үүсгэж байна.

Түүнчлэн, Санхүүгийн зохицуулах хорооны санхүү, төсвийн хязгаарлагдмал байдалтай холбоотойгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид, мэргэжлийн оролцогчид болон иргэдэд чиглэсэн сургалт, мэдээллийн хүртээмж хангалттай хэмжээнд хүрч чадахгүй байна.

Эцэст нь санхүүгийн зах зээл дэх хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах шүүхийн өмнөх шатанд санхүүгийн зах зээлийн маргаан шийдвэрлэх механизм болон хөрөнгө оруулагч, даатгуулагч, хадгаламж эзэмшигчийг хамгаалах сангийн эрх зүйн тогтолцоо бүрдээгүй.

### Цаашид хэрэгжүүлэх асуудлууд:

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах хяналт, зохицуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд:

- 1) Монгол Улс дахь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах стратегийг боловсруулж, батлуулах;
- 2) Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах чиглэлээр зах зээлийн мэдээ болон өргөдлийн мэдээлэл цуглуулах, ашиглах, хадгалах, судалгаа, шинжилгээ, бодлогын шийдвэр ба хяналт, зохицуулалтын дүрэм, журмыг боловсруулах чиг үүрэг бүхий албыг бий болгох;
- 3) Хорооны хянан шалгагчдыг хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах чиглэлээр мэргэшүүлэх;
- 4) Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах тусгайлан цогц журмын зохицуулалтыг бий болгох;
- 5) Олон улсын болон гадаад орнуудын зохицуулагч, хяналтын байгууллагуудтай мэдлэг, мэдээлэл, туршлага солилцож, гадаад хамтын ажиллагааг идэвхжүүлэх;
- 6) Хадгаламжийн даатгалын системд бусад санхүүгийн үйлчлүүлэгчдийг хамруулах эрх зүйн тогтолцоог бий болгох;

- 7) Санхүүгийн зах зээлд шүүхийн өмнөх шатны Маргаан шийдвэрлэх механизмын эрх зүйн тогтолцоог бий болгох.

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалахад зах зээлд оролцогчдын оролцоог нэмэгдүүлэх хүрээнд:

- 1) Монголбанк, Сангийн яамтай харилцан мэдээлэл солилцох, хяналт, зохицуулалтын чиг үүргүүдийг зохистойгоор хуваарилан төрийн ажлын үр дүн, уялдааг сайжруулах;
- 2) Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг дээдэлсэн, нийгмийн хариуцлагатай санхүүгийн байгууллагыг дэмжих;
- 3) Санхүүгийн байгууллагын засаглалыг сайжруулах;
- 4) Мэргэжлийн байгууллагуудын санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналыг ил тод болгох;
- 5) Мэргэжлийн холбоодыг чадваржуулах, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг хамтран сахиулах;
- 6) Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагад үе шаттайгаар шилжүүлэх.

Санхүүгийн хэрэглэгчийг чадваржуулах хүрээнд:

- 1) “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх;
- 2) Санхүүгийн зах зээлд оролцогчид, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэлэлцүүлэг, сургалтыг тогтмол зохион байгуулах;
- 3) Олон нийтийг шаардлагатай мэдлэг, мэдээллээр хангах, түгээмэл асуулт хариулт, иргэдийн санал, гомдлыг хүлээн авч барагдуулах цахим механизмыг бүрдүүлэх.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнгийн төсөөлөл:

- 1) Иргэдийн санхүүгийн зохицуулагч болон үйлчилгээ үзүүлэгч байгууллага, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдлэг нэмэгдэнэ;
- 2) Иргэд өөрсдийн эрх болон үүрэг хариуцлагын талаар бүрэн мэдээлэлтэй болсноор иргэдийн санхүүгийн болоод эрх зүйн хариуцлага нэмэгдэнэ;
- 3) Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, санхүүгийн үйлчилгээний зардал буурснаар хүртээмж сайжирна;
- 4) Компаниудын засаглал, мэдээллийн ил тод байдал хангагдаж, хөрөнгө оруулагч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоо олон улсын стандартад нийцсэнээр иргэдийн зах зээлд итгэх итгэл нэмэгдэнэ;
- 5) Санхүүгийн зах зээлд оролцогчдын цар хүрээ, улмаар өрсөлдөөн нэмэгдэн санхүүгийн хүртээмж сайжирснаар санхүүгийн салбарын тогтвортой хөгжил хангагдана.

## ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МӨРӨӨР – МЭДЭЭЛЭЛ

### МУТСТ ЧИГЛЭЛЭЭР САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АРГА ХЭМЖЭЭ

МУТСТ тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т хамаарах банкнаас бусад санхүүгийн байгууллагууд болох банк бус санхүүгийн байгууллага, даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, хадгаламж зээлийн хоршоо, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага болон үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагууд тус хуульд заасан гүйлгээний талаарх мэдээллийг СМА-д мэдээлэх ба тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлдэг.

Мөн ФАТФ-ын Техникийн хэрэгжилтийн үнэлгээний 40 зөвлөмжийн 23, Үр дүнтэй байдлын үнэлгээний 11 зөвлөмжийн 4-ийг Санхүүгийн зохицуулах хороо дангаар болон бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнээс гадна Засгийн газрын 2017 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, 327 дугаар тогтоолоор батлагдсан “Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-нд Санхүүгийн зохицуулах хороонд хариуцуулсан ажлуудыг гүйцэтгэдэг.

Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд Санхүүгийн зохицуулах хорооноос өнгөрсөн хугацаанд чамгүй ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд голлох ажлуудыг багцлан дурдвал дараах байдалтай байна. Үүнд:

#### Хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр

1. Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудтай хамтран МУТСТ хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн тухай хууль болон Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд МУТС тухай хуулийн төсөл 2018 оны 04-р сарын 26-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар батлагдсан.
2. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 239 дүгээр тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх

хяналт шалгалт хийх журам”-ыг баталсан.

3. Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2018 оны 627 дугаар тушаалаар дараах баримт бичгүүдийг баталсан. Үүнд:

–“Мэдээлэх үүрэгтэй этгээдээс санхүүгийн зохицуулах хороонд ирүүлдэг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны улирлын тайлан, мэдээний загвар”

–“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний аргачлал”

–“Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тоон болон чанарын өгөгдөл цуглуулах маяг”

–“Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх асуулга”

–“Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээний матриц”-ийг тус тус баталсан.

4. МУТСТ чиглэлийн зохицуулалтуудыг салбар бүрийн онцлогт нийцүүлэн “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”, “Даатгалын багц дүрэм”, “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”, “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага” зэрэг эрх зүйн актуудад тусгасан.

#### Хяналт, шалгалтын чиглэлээр

Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулдаг этгээд 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 2347-д хүрсэн бөгөөд эдгээр байгууллагад МУТСТ чиглэлийн хяналт шалгалтыг үр дүнтэй хийх үүднээс эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж байна.

Өөрөөр хэлбэл мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн мэдээлэлд үндэслэн зайны хяналт шалгалтыг хийсний үр дүнд эрсдэл өндөр байгууллагуудад газар дээрх хяналт шалгалтыг хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооноос Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа банкнаас бусад

санхүүгийн салбарын мэдээлэх үүрэгтэй давхардсан тоогоор нийт 1121 этгээдүүдийн үйл ажиллагаанд МУТСТ чиглэлээр газар дээрх хяналт шалгалт болон эрсдэлийн үнэлгээг 2018 онд хийж гүйцэтгэсэн.

Мөн МУТСТ тухай хуулийн дагуу үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамаарах болсноор тус салбар дахь эрсдэлийг тодорхойлох ажлын хүрээнд “Үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх түүвэр судалгаа”-г боловсруулсан.

Эдгээр эрсдэлийн үнэлгээнүүдэд үндэслэн 2019 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийгдэх эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу 2019 оны эхний хагас жилд нийт 86 мэдээлэх үүрэгтэй этгээдэд газар дээрх хяналт шалгалт хийж, дүгнэлтийг боловсруулсан.

#### Сургалт, урьдчилан сэргийлэх чиглэлээр

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд МУТСТ чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байх, МУТСТ тухай хууль, дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилж ажиллуулах, 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх зэрэг МУТСТ тухай хуульд заасан бүхий л үүргээ биелүүлэхийг анхааруулж, сургалт явуулж, зөвлөмж хүргүүлэх ажлыг тогтмол хийж байна.

Түүнчлэн, мэдээлэх үүрэгтэй этгээдүүд харилцагчийг таньж мэдэх тогтолцоог бүрдүүлж эцсийн өмчлөгч болон улс төрд нөлөө бүхий этгээдийг тогтоох, сэжигтэй гүйлгээг мэдэх зэрэг үндсэн тогтолцоотой болоход Санхүүгийн зохицуулах хорооноос ихэд анхаарч, холбогдох албан тушаалтнуудад зориулсан сургалт, семинар, форумуудыг тогтмол зохион байгуулж ирлээ. Тухайлбал, дараах голлох сургалтуудыг дурдаж болно. Үүнд:

1. “Санхүүгийн салбарын комплаенс” нэрт томоохон хэмжээний хэлэлцүүлгийг 2018, 2019 онуудад зохион байгуулсан. Хоёр

- удаагийн хэлэлцүүлэгт зохицуулалтын байгууллагууд болон Үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд, мөн Азийн сан, Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банкны суурин төлөөлөгч зэрэг байгууллагуудаас нийт 400 гаруй зочид төлөөлөгчид оролцож МУТСТ чиглэлээр салбар бүрийн хувьд тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийн боломжит шийдлүүдийн талаар хэлэлцсэн.
- МУТСТ чиглэлээр Хороо болон зохицуулалтын хүрээний байгууллагуудын 1,000 гаруй ажилтнуудыг чадавхжуулах 30 гаруй сургалтыг орон даяар үе шаттайгаар зохион байгуулав.
  - МУТСТ чиглэлээр хууль сахиулах болон төрийн бусад байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулсан.
  - ББСБХ, ҮЦАЭХ, Хуульчдын холбоодтой хамтран зохицуулалтын байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулж байгаа бөгөөд ББСБХ-той хамтран “Комплаенс ба ёс зүй” сэдэвт цахим сургалтад бүх ББСБХ-ын комплаенсын ажилтнуудыг хамруулаад байна.
  - “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх гарын авлага”, “Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын комплаенсийн ажилтнуудад зориулсан гарын авлага”-уудыг боловсруулж зохицуулалтын байгууллагуудад хүргүүлэв.

### ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ГАЗАР ДЭЭРХ БОЛОН ЗАЙНЫ ХЯНАЛТААР ИЛЭРДЭГ НИЙТЛЭГ ЗӨРЧИЛ ДУТАГДАЛ

Даатгалын компаниудын газар дээрх шалгалтаар нийтлэг дараах зөрчил дутагдал гардаг. Үүнд:

- Даатгалын тухай хууль болон багц дүрэмд заасны дагуу Хорооноос зөвшөөрөл авалгүй компанийн ТУЗ-ийн гишүүн, эрх бүхий албан тушаалтнуудыг шууд томилох;
- Компанийн жил, улирлын санхүүгийн болон даатгалын нэмэлт тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд цаасаар болон Санхүүгийн зохицуулах хорооны цахим бүртгэл (FINA программ)-д илгээнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэлгүй, хоцроох, ирүүлэхгүй байх;
- Даатгалын байгууллагууд салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл, татан буулгах шийдвэр хүсэлтийг Хороонд ирүүлж хянуулж бүртгүүлэхгүй үйл ажиллагаа явуулах. Мөн олон нийтэд

хэвлэл мэдээллийн хэрэгслээр аудитаар баталгаажуулсан тухайн жилийн санхүүгийн тайлан, дүгнэлтийг мэдээлэхгүй байх;

- Даатгалын төлөөлөгчийн, зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй этгээдтэй хамтарч ажиллан тэдгээрт зарим даатгагч нар даатгалын орлогын шимтгэл буюу зуучлалын хөлс олгох;
- Компанийн үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын нэгж, эсхүл албан тушаалтангүй, ТУЗ-өөр батлуулсан дотоод хяналтын үйл ажиллагаанд мөрдөх журамгүй байх, эсхүл зарим тушаалтан хавсран гүйцэтгэж байгаа гэх нэрээр хэлбэрийн төдий байдаг;
- Даатгагч өөрийн төлбөрийн чадварын зохистой харьцааны үзүүлэлтийг тооцохдоо зөвшөөрөгдөхгүй хөрөнгө, авлагын насжилтийг үнэн зөв тооцож гаргахгүй байх, мөн ногдол ашиг хуваарилахын өмнө буюу дараа нь төлбөрийн чадварын зохистой харьцааны үзүүлэлтийг хангаагүй, хангахгүй байх нөхцөлд ногдол ашиг хуваарилах;
- Зарим даатгагч даатгалын шинэ бүтээгдэхүүнийг гаргахаас өмнө мөн хуучин бүтээгдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулаад Хороонд бүртгүүлэлгүй зах зээл дээр гаргаж даатгуулагч нартай гэрээ байгуулж борлуулалт хийх;
- Хороонд давхар даатгалын төлөвлөгөө төлөвлөгөө, тайланг багц дүрэмд заасан хугацаанаас хоцроож, хавсралт давхар даатгалын гэрээний хуулбарыг дутуу ирүүлэх;
- Зарим даатгуулагч нарт хохирлын нөхөн төлбөр олгохоос татгалзахдаа хуульд заасны дагуу албан бичгээр /утсаар болон өөрт нь мэдэгдсэн гэсэн тайлбартайгаар/ хариу өгөхгүй байх;
- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хохирлын нөхөн төлбөрийг олгохдоо тухайн хохирлыг үнэлсэн үнэлгээний төлбөрийн даатгуулагч нарт хууль заасны дагуу олгохгүй байх;
- Зарим даатгалын компани дүрмийн сангийн болон даатгалын нөөц сангийн мөнгөн хөрөнгийг өөрийн холбогдох этгээд болон түүний үүсгэн байгуулсан банкинд байршуулахыг хуулиар хориглосоныг хэрэгжүүлэхгүй байх;
- Компани өөрийн дүрмийн болон нөөц сангийн хөрөнгийн байршлын шаардлагыг алдагдуулах, санхүүгийн, даатгалын нэмэлт тайлан хоорондын тоон мэдээллийг зөрүүтэй тайлагнах;
- Нөөц сан дутуу тооцоолох, авлагын насжилтыг хийхгүй байх, төлбөрийн

чадварын шалгуур үзүүлэлтийг журамд зааснаар тооцохгүй зэрэг алдаа дутагдлыг гаргаж байна.

Даатгалын байгууллагуудад хийсэн газар дээрх шалгалт болон зайны хяналтаар илэрсэн алдаа дутагдлыг засаж залруулах хугацаатай үүрэг даалгаврыг шалгалтын тайлан, албан бичиг, улсын байцаагчийн албан шаардлагаар өгч хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулж ажилладаг.

Илэрсэн зөрчлүүдэд 2018 онд 173.5 сая төгрөгийн, 2019 оны эхний хагас жилд 53.2 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээг Зөрчлийн тухай хуульд заасны дагуу ногдуулж ажилласан.

### БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ГАЗАР ДЭЭРХ БОЛОН ЗАЙНЫ ХЯНАЛТААР ИЛЭРДЭГ НИЙТЛЭГ ЗӨРЧИЛ ДУТАГДАЛ

Банк бус санхүүгийн байгууллагуудад эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид үндэслэн дараах байдлаар гүйцэтгэж байна. Тухайлбал:

- Хорооны 2008 оны 157 дугаар тогтоолоор баталж, 2013 оны 530 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх журам”-ыг үндэслэн газар дээрх бүрэн хэмжээний хяналт шалгалтууд;
- Харин зайны болон хэсэгчилсэн, төрөлжсөн хяналт шалгалтуудыг “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам, Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам, Банк бус санхүүгийн байгууллагаас зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам бусад холбогдох журмуудад үндэслэн тус тус гүйцэтгэж байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудад газар дээрх шалгалтаар нийтлэг дараах зөрчил дутагдал илэрдэг. Үүнд:

- Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн ерөнхий болон нэмэлт нөхцөл шаардлагыг бүрэн ханган ажиллаагүй;
- ББСБХ-ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд зориулагдсан мөнгөн

хөрөнгө ББСБ–ын харилцах, хадгаламжийн дансанд байршаагүй, хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагын хувийн харилцах, хадгаламжийн дансуудад байршсан;

3. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд мөрдөх журам, зааваргүй;
4. Компанийн дүрэм, үйл ажиллагаанд мөрдөж буй журам, заавар нь холбогдох хууль, журмын заалтуудтай зөрчилдсөн;
5. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг эрхлээгүй;
6. Тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа / нэмэлт зөвшөөрөл аваагүй/ эрхэлсэн;
7. Зөвшөөрөлгүйгээр салбарын үйл ажиллагаа эрхэлсэн;
8. Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаагүй;
9. Хороонд төвлөрүүлбэл зохих зохицуулалт үйлчилгээний хөлсийг төлөөгүй;
10. Монголбанкны Зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулаагүй;
11. Гүйцэтгэх удирдлага нь нөхцөл, шаардлагыг хангаагүй;
12. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Компанийн засаглалын сургалтад, гүйцэтгэх удирдлага нь МББСБХ–ноос зохион байгуулагдаж буй сургалтад тус тус хамрагдаагүй;
13. Хороонд бүртгэлтэй ажлын байранд үйл ажиллагаа явуулаагүй, хаягийн өөрчлөлтийг Хороонд бүртгүүлээгүй;
14. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн ханган ажиллаагүй;
15. Хороонд ирүүлвэл зохих сар, улирал тутмын тайлан мэдээг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд хэвлэмэл байдлаар болон Санхүүгийн зохицуулах хорооны цахим бүртгэл (FINA)–д хоцроох, ирүүлэхгүй байх;
16. Жилийн эцсийн санхүүгийн тайланг Аудитын байгууллагаар баталгаажуулан, тухайн баталгаажуулсан тайлан, дүгнэлтийг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхгүй байх;

Банк бус санхүүгийн байгууллагуудад хийсэн газар дээрх шалгалт болон зайны хяналтаар илэрсэн алдаа дутагдлыг засаж залруулах хугацаатай үүрэг даалгаврыг шалгалтын тайлан, тайлангийн хариу, улсын байцаагчийн албан шаардлагаар тус тус өгч хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулан, мөн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байна.

Илэрсэн зөрчлүүдэд 2018 онд 85.6 сая төгрөгийн, 2019 оны эхний хагас жилд 8.0 сая

төгрөгийн торгуулийн арга хэмжээг Зөрчлийн тухай хуульд заасны дагуу ногдуулж, Хорооны хуралдаанаар 2018 онд 42 асуудал, 2019 оны эхний хагас жилийн байдлаар 18 асуудал хэлэлцүүлэн шийдвэрлүүлэн ажилласан.

**ХЭХ–ДЫГ ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ ЗАРИМ АСУУДАЛ**

Нийгэм, эдийн засгийн харилцаа хөгжихийн хэрээр иргэд амьдралаа сайжруулах зорилгоор хөдөлмөр, хөрөнгөө нэгтгэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх замаар хамтын зохион байгуулалттай болж ирсний нэг хэлбэр нь хоршоо юм. Хоршооллын хөдөлгөөний сонгодог хэлбэр бол Хадгаламж, зээлийн хоршоо.

Хоршооллын философийн үндэслэгчид нь Роберт Оуэн (Robert Owen), Шарль Фурье (Charles Fourier) нарыг гэж үздэг. Тэд хоршооны эдийн засгийн давуу талыг тайлбарлаж, хоршоог аж ахуйн нэг хэлбэр мөн гэж үзсэн байна.

Английн Рочдейл (Rochdale) хотын оёдолчид 1844 онд хоршиж, нэгдэж байсан бол үүнээс хойш 10 гаруй жилийн дараа 1860–аад онд Герман улсад байгуулагдсан байна. Хоршооны хөдөлгөөнийг үндэслэсэн 2 хүний нэг Германы улс төрч, эдийн засагч Херман Шульце–Делич (Herman Schulze–Delitzsche) жижиг гар урчууд болон хотын дундаж орлоготой хүмүүст, Германы нийгмийн зүтгэлтэн Фридрих Вильгелм Райффайзен (Frederich Wilhelm Raiffesen) орон нутгийн тариачдад зориулан зээлийн хоршоог байгуулахдаа хүмүүсийг хамтын зохион байгуулалтанд оруулж, санхүүгийн зах зээлд оролцох боломжийг олгож, хамтын хүчээр өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг эргэлтэнд оруулах, үр ашиг хүртээх замаар амьжиргааг нь дээшлүүлэх хоршооллын философийн суурь зарчмыг бий болгоход маш чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Энэхүү зарчим өнөөдөр ч үндсэн утгаа алдахгүйгээр хөгжиж байна.

Үүний дараа Итали улсад Луйги Луззатти хоршооны хөдөлгөөнийг өрнүүлж, улмаар Европын улсуудад түгэн тархсаар өөрсдөдөө туслах, зээлийн нийгэмлэг хэлбэрээр байгуулагдах болжээ.

Дэлхийн улс орнуудын чиг хандлагаас үзэхэд хадгаламж, зээлийн хоршоодын санхүүгийн үйлчилгээ ихэвчлэн ядуу болон бага орлоготой иргэдэд чиглэж, тэдний мөнгөний эрэлт, хэрэгцээг хангах гол эх үүсвэр болсон.

Ардчиллын үндсэн дээр бие даах, өөрийгөө хамгаалах, нийгмийг эрүүлжүүлэх, нийгмийн өмнө хүлээх үүргээ ухамсарлах зэрэг бүхий л үнэт зүйлст тулгуурласан ашгийн төлөө бус нөхөрлөл хэлбэрээр, зарим нь олон нийтийн

байгууллагын статустайгаар үйл ажиллагаагаа явуулсаар тив, дэлхийн хэмжээний зохион байгуулалттай болтлоо хөгжсөөр зуу гаруй болжээ.

Монгол улсын хувьд УИХ–аас 1995 оны 5 дугаар сарын 06–ны өдөр “Хоршооны тухай” хууль батлагдаж, улмаар 2002 оны 12 дугаар сарын 12–ны өдөр хуулинд “Хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа” гэсэн бүлгийг нэмснээр хууль эрх зүйн зохицуулалттай болгосон байна.

Анхны ХЗХ–д 1990–ээд оны сүүлийн хагас буюу 1996 оноос эхлэн байгуулагдсан гэж үздэг.

АХБ–ны “Ажлын байр нэмэгдүүлэх төсөл”–ийн хүрээнд 1996 оны 9 дүгээр сард олон улсын мэргэжилтнүүд ирж анх удаа ХЗХ–ны талаар суурь ойлголтыг төрийн бус байгууллагуудад танилцуулсан нь Монголын хадгаламж, зээлийн хоршооны хөдөлгөөн өрнөхөд чухал нөлөө үзүүлсэн юм.

Тухайн үед аж ахуйн нэгжүүд болон иргэдэд санхүүгийн эх үүсвэр дутагдалтай, эрэлт ихтэй байсныг далимдуулан Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоод олноор байгуулагдаж, 1998 онд 18 ХЗХ, 2001 онд 58 байсан ХЗХ–дын тоо 2005 он гэхэд 900 гаруйд хүрсэн.

Хоршоод гишүүдийнхээ нийтлэг хэрэгцээг хангахаас илүүтэйгээр нэг хэсэг нь иргэдийг өөртөө татахын тулд бие биенээсээ өрсөн эдийн засгийн тооцоо, судалгаагүйгээр олон нийтэд өндөр хүү амлан мөнгөн хадгаламж татаж, хүмүүсийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж хувьдаа шамшигдуулах, үл хөдлөх хөрөнгө худалдан авах зэргээр хууль бусаар хөрөнгөжих болсон байна.

Харин нөгөө хэсэг нь өртөг ихтэй хадгаламжийн эх үүсвэрээр өндөр хүүтэй зээл олгож, иргэдийг зээлийн дарамтад оруулах болсон бөгөөд тэдний бизнесийг дэмжихээсээ илүү дампууруулах хэрэгсэл болон хувирсан юм.

Дээрх нөхцөл байдал нь нийгэмд бухимдал үүсгэж иргэд, олон нийтэд Хадгаламж, зээлийн хоршоо хэмээх аж ахуйн нэгжийг “Өндөр хүүг худал амлаж, хүмүүсийн мөнгийг луйварддаг хэсэг зальт хүмүүсийн байгууллага” мэтээр ойлгоход хүргэсэн байдаг.

Санхүүгийн зах зээл дэх хоршооллын хөдөлгөөнийг зарим ХЗХ–ны удирдлагууд буруугаар ашиглаж, бусдыг залилах, хууран мэхлэх арга хэрэгслээ болгосон нь 26 ХЗХ дампуурч, түүнд холбогдох 8300 иргэний 72.4 тэрбум төгрөгийн хохирол учруулсан хор уршигтай явдал байв.

Хэдийгээр энэ үед хоршооны хуулийн зохицуулалт дутмаг, төрийн хяналт сул байсан хэдий ч дампуурах гол шалтгаан нь хоршоод үндсэн зарчмынхаа дагуу үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой.

Иргэдэд учруулсан хохирлыг арилгах, үүссэн нөхцөл байдлыг зохицуулахын тулд УИХ, Засгийн газраас буруутай этгээдүүдийн асуудлыг шүүхээр шийдвэрлүүлж, зарим ХЗХ-г татан буулгах, ХЗХ-ны үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр төрийн хяналт, зохицуулалтад оруулан эрх зүйн орчныг нь сайжруулах зэрэг олон арга хэмжээ авч ажилласан нь тодорхой үр дүнд хүрсэн байна.

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Хоршооны тухай” хуульд хадгаламж, зээлийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид СЗХ гэх/-ноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг хуулиар СЗХ-ны зохицуулалтад ХЗХ-г хамруулах, хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохоор заасан.

СЗХ 2006 онд байгуулагдан уг салбарын үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийх төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх болсон.

Өнөөгийн байдлаар буюу 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөлтэй 282 ХЗХ хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 178 ХЗХ нь нийслэл Улаанбаатар хотод, 104 ХЗХ нь хөдөө, орон нутагт байна. Өөрөөр хэлбэл 21 аймагт ХЗХ-д үйл ажиллагаа эрхэлж байна.

Үүнээс гадна Хорооны зөвшөөрлөөр 113 ХЗХ төслийн санхүүжилтийн үйлчилгээ, 3 ХЗХ санхүүгийн түрээсийн үйлчилгээ, 3 ХЗХ даатгалын төлөөлөгчийн үйлчилгээ, 7 ХЗХ салбарын үйл ажиллагаа тус тус эрхэлж байна.

ХЗХ-дын нийт гишүүдийн тоо 66,296 болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 15.0 хувиар буюу 8,637-оор өслөө.

ХЗХ-дын нийт хөрөнгийн хэмжээ 211.7 тэрбум төгрөгт хүрсэн нь 1 жилийн өмнөх мөн үеэс 31.7 хувийн өсөлтийг үзүүлжээ.

Тайлант хугацаанд тайланд орсон 282 ХЗХ-ны нийт хөрөнгийн 83.4 хувийг нэг тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 20 ХЗХ, 12.9 хувийг 100 саяас нэг тэрбум хөрөнгөтэй 120 ХЗХ, үлдсэн буюу 3.7 хувийг 100 саяас доош хөрөнгөтэй 142 ХЗХ-д бүрдүүлж байна.

Манай улсын хувьд ХЗХ нь санхүүгийн салбар дахь тэгш эрх бүхий гишүүнчлэлтэй, харилцан итгэлцэлд тулгуурласан нийтийн зохион байгуулалт бүхий шинэ байгууллага тул санхүүгийн гэмт хэрэг, зөрчил, аливаа эрсдэлээс сэргийлэх нь нэн тэргүүний чухал шаардлага хэвээр байна.

Дэлхийн банкнаас 2012 онд Монгол Улсын санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж буй байдал, иргэд олон нийтийн эдийн засаг, санхүүгийн боловсролыг олон улсын төвшинтэй харьцуулсан судалгаагаар хангалтгүй гэсэн дүгнэлт гаргасан.

Гишүүдийн санхүүгийн мэдлэг сайн байх нь салбарын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, гишүүдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх, хуримтлал бий болгох, санхүүгийн хэрэгцээгээ зөв тодорхойлох, зээлийн хөрөнгийг зөв удирдах, санхүүгийн эрх үүргээ бүрэн ойлгох гэх мэт олон талын үр ашигтай.

Санхүүгийн зах зээлд иргэн бүхэн оролцож байгаа бол тиймээс санхүүгийн мэдлэгтэй байвал аливаа санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, оновчтой шийдвэр гаргах, хувийн болон өрхийн санхүүгээ удирдах зөв дадал, хэвшилтэй болно.

Тиймээс хэрэв та ХЗХ-ны гишүүн болох гэж байгаа л бол зөвхөн зээл авах, хадгаламж хадгалуулахын тулд сонгох бус тэр ХЗХ-ны санхүүгийн сахилга бат, гишүүдээ чиглэсэн арга хэмжээ, нэр хүнд, үйл ажиллагаа нь хоршооны зарчмаар явагддаг эсэх, санхүүгийн тайлан, санхүүгийн чадавх, хадгаламж болон хүүгийн төвшинг судалж, зохицуулалтын хууль тогтоомжийг уншиж ХЗХ-ны талаар мэдлэгтэй болж сонгох хэрэгтэй.

Учир нь ХЗХ бол гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүдээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээд юм. Хэрэв та ХЗХ-ны гишүүн болсон бол та гишүүний эрх, үүрэг хариуцлага мэдэх ёстой.

#### Тэгвэл та ямар үүрэгтэй вэ гэвэл:

1. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд оролцож, үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, түүний санхүү, эдийн засгийн болон хөрөнгийн байдал, жил, улирлын санхүүгийн тайлан, мэдээ, тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн шийдвэр, тэдгээрийн үйл ажиллагааны тайлан, бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, гишүүдийн бүртгэлтэй тогтмол танилцах;
2. Хувь хөрөнгийг тогтоосон хугацааны дотор оруулах;
3. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд биечлэн оролцох, бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, гүйцэтгэх захирлын гаргасан шийдвэрийг биелүүлэх;
4. Хадгаламж, зээлийн болон бусад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
5. Гишүүний бүртгэлд тусгагдсан мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр шуурхай мэдэгдэх.

#### Таны гишүүний хариуцлага бол:

1. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль болон бусад хууль, тогтоомж, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас хадгаламж, зээлийн хоршоонд учруулсан хохирлыг иргэн хувийн өмчийн хөрөнгөөр, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр бүрэн барагдуулна.
2. Хадгаламж, зээлийн хоршооны бусдын өмнө хүлээх хариуцлагыг гишүүн нь зөвхөн өөрийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээгээр хариуцах ба хувийн өмчийн хөрөнгөөрөө хариуцахгүй.
3. Хадгаламж, зээлийн хоршоонд учруулсан хохирлыг нөхөн төлөхөөс зайлсхийх зорилгоор, эсхүл хууль бус үйлдлээ халхавчлах үүднээс олсон ашиг, орлого, эд хөрөнгөө бусдын өмчлөлд буюу хамтран өмчлөх дундын эд хөрөнгөнд шилжүүлсэн нь нотлогдвол тэр хэмжээгээр тухайн эд хөрөнгөөс төлбөр гаргуулна.
4. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 27.1-д заасан зөрчлийн улмаас гишүүнээс хассан буюу гишүүний эрхийг түдгэлзүүлсэн нь тухайн гишүүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа хэвийн, тогтвортой явагдахад гишүүний таны үүрэг хариуцлагаас гадна олон хүчин зүйл нөлөөлж байгаа бөгөөд тэдгээр хүчин зүйлсийг зөв үнэлснээр учирч болзошгүй эрсдэлээс ХЗХ өөрийгөө урьдчилан сэргийлэх боломжтой. Үүнд:

1. Бүх гишүүдийг төлөөлөн сонгогдсон Тэргүүлэгчдийн болон Хяналтын зөвлөл, Зээлийн хорооны дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх, үүргийн хэрэгжилтийг хянаж, дүгнэх хөндлөнгийн тогтолцоог нэвтрүүлэх, засаглалыг сайжруулах, боловсон хүчнийг мэргэшүүлэх;
2. Бүх гишүүдийн нэрийн өмнөөс ажиллаж байгаа хяналтын зөвлөл нь удирдлагын бусад нэгжүүдийнхээ хуулиар олгогдсон бүрэн эрхийн хэрэгжилтийг дүгнэж, гишүүдэд ил тод мэдээлэх ажлыг тогтмолжуулах, санхүүгийн тайлагналын үнэн зөв, бодитой байдлыг хянах зэрэг дотоод хяналтыг үр дүнтэй гүйцэтгэх;
3. Бүх гишүүдийг төлөөлөн сонгогдсон хүмүүсийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, цалин урамшууллыг ХЗХ-ны үйл ажиллагааны үр дүнтэй уялдуулах, эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
4. ХЗХ-ны гишүүдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх тогтолцоог бий болгох;
5. Хэм хэмжээгээр тогтоосон журам, зааврыг мөрдсөнөөр хоршооны үйл ажиллагааг

санхүүгийн эрсдэлээс хамгаалах гол арга болохыг ХЗХ бүр ойлгох нь ач холбогдолтой. Активын ангилал, дансдуудад байршсан хөрөнгийн байдлаас тухайн ХЗХ-ны мөнгөн хөрөнгийн урсгалыг тооцож байх хэрэгтэй. Санхүүгийн үзүүлэлтүүд хэдий сайн боловч мөнгөн хөрөнгийн орох, гарах урсгал саатаж буй эсэхийг сайтар анхаарах. Зээлийн эрэлтээс илүү хэмжээний мөнгөн хадгаламж болон өртөг өндөртэй эх үүсвэр татсан эсэхийг ч авч үзэх;

- Өөрийн хөрөнгө ба өр төлбөрийн харьцаа түүнчлэн өөрийн хөрөнгийн бүтэц, хүрэлцээний талаар судалж, өөрийн хөрөнгийн эрсдэл даах чадвар ямар байгааг авч үзэх;
- Тэнцлийн гадуурх дансанд бүртгэлтэй хөрөнгийн байдалд дүгнэлт өгч ажиллах.

## ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Хороо үнэт цаасны зах зээлд эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, үнэт цаас гаргагч буюу хувьцаат компанийн үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг бууруулах бодлогыг баримтлан ажиллаж ирсэн.

Тус ажлын хүрээнд төрийн болон хувийн өмчит хувьцаат компаниудад хувьцаа эзэмшигчдийн

хурлыг хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасан шаардлага, Хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тус тус үүрэг болгон жил бүрийн 1 дүгээр сард албан бичгээр хүргүүлдэг.

Компанийн тухай хуулийн дагуу хувьцаат компани (ХК)-ууд Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)-аа санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор буюу дөрөвдүгээр сарын 30-наас өмнө зарлан хуралдуулахаар заасан.

Хууль болон журамд нарийвчлан заасан цаг хугацааг графикаар харуулбал дараах байдалтай байна.

2019 оны хувьд Хороонд бүртгэлтэй нийт 305 ХК-аас 155 ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь ХЭХ-аа хуралдуулах шийдвэрээ хуулийн хугацаанд гаргаж, Хороонд мэдэгдлээ ирүүлсэн бөгөөд 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 139 ХК хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулан Хороонд хурлын материалаа ирүүлээд байна.

хуулийн дагуу үүргээ хэрэгжүүлэхгүй байна.

2019 онд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуралдуулж Хороонд ирүүлсэн материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” хянаж үзэхэд дараах нийтлэг алдаанууд илэрсэн. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй жагсаалтыг бүртгэлийн өдрөөр гаргаж ирүүлээгүй;
- Журмын 3.3-т “Хурал зарлагч этгээд нь хурлын зарыг хурал хуралдахаас 30 болон түүнээс багагүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан хоёр ба түүнээс дээш удаа хувьцаа эзэмшигчдэдээ мэдээлнэ” гэж заасны дагуу зар мэдээ хүргэснийг нотлох баримтыг ирүүлээгүй;
- Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-д “Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийг хурлын тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглоно” гэж заасныг хангасан эсэх талаарх мэдээллийг ирүүлээгүй;
- Компанийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хуралд төлөөлөн оролцох эрхийг баталгаажуулсан итгэмжлэлийг ирүүлээгүй;
- Журмын 2.10.4-д “Тооллогын комиссын дарга, гишүүдийн анкет” гэж заасныг ирүүлээгүй;
- Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн эсэх талаарх мэдээллийг ирүүлээгүй;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх мэдээлэл ирүүлээгүй;
- Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т “Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын

Тус үзүүлэлтийг өмнөх жилүүдтэй харьцуулан харуулбал дараах байдалтай байна.



Түүнчлэн Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-д “Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна” гэж заасны дагуу хуулийн хугацаанд нийт 103 ХК ТУЗ-ийн шийдвэрээ Хороонд ирүүлсэн бөгөөд үүнээс 29 ХК нь нийт 109.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 63,082 хувьцаа эзэмшигчид олгохоор шийдвэрлэсэн байна.

Мөн Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5-т “Энэ хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон

компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно” гэж заасны дагуу 2019 онд 53 ХК-уудын ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг ээлжит бусаар зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрхгүй болсон, тус бусад бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш эдгээр ТУЗ-үүдтэй байгуулсан аливаа гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус болохыг тус ХК-уудын хувьцаа эзэмшигч, удирдлага, харилцагч байгууллага болон бусад холбогдох этгээдүүдэд Хороо цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажилласан. Уг компанийн тоо 2017 онд 52 ХК, 2018 онд 55 ХК байсан байна.

Хороонд бүртгэлтэй нийт 305 хувьцаат компаниас 50 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани байна. Гэвч дээрх компаниуд нь Компанийн тухай

гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ” гэж заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн дэд хороодыг байгуулсан талаарх холбогдох тогтоол, шийдвэрийг ирүүлээгүй;

9. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6–д заасны дагуу Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороонд ирүүлээгүй зэрэг нийтлэг алдаа, дутагдал илэрсэн.

### ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААР

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03–ны өдрийн 299 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.3–т “Олон улсын стандартад нийцсэн зохицуулалт, хяналт, тусгай зөвшөөрлийн шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг оновчтой байдлаар тогтоох, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар үнэт цаасны зах зээлийн дундын зуучлагчдын чадавхыг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ” гэж тусгагдсан.

Хороо нь Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага IOSCO/-ын гишүүний хувьд тус байгууллагаас гаргасан зарчим, зөвлөмжийг баримтлан ажилладаг. Тус байгууллагаас “Үнэт цаасны зах зээлийн оролцогчид нь эрсдэлээ даахуйц, хангалттай хэмжээний Хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байх шаардлагатай” гэж зөвлөсөн байдаг.

Зөвлөмжийн дагуу үнэт цаасны зах зээлийн оролцогчдын хувь нийлүүлсэн хөрөнгийг шинэчлэн тогтоох замаар тэдгээрийн чадавхыг бэхжүүлэх шаардлагатай болсон.

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагууд нь банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын компаниудаас үйл ажиллагааны чиглэлээр ялгаатай дараах шинжийг агуулдаг. Үүнд:

1. Өөрийн хөрөнгийг харилцагчийн хөрөнгөөс тусад нь бүртгэдэг;
2. Харилцагчаас хөрөнгө татан төвлөрүүлсэн активын удирдлагыг хэрэгжүүлдэггүй;
3. Зах зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлээс хөрөнгө оруулагч харилцагчийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн нөөц сангуудын мөнгөн хөрөнгө, дилерийн өөрийн хөрөнгөөр худалдан авсан хөрвөх чадвар өндөртэй үнэт цааснаас актив бүрддэг тул бусад санхүүгийн байгууллагын

балансын бүртгэлээс цомхон шинжтэй;

4. Үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоо, бүртгэл, хадгаламжийг тусгай зөвшөөрөл бүхий өөр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлдэг.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 2002 онд батлагдсанаар анх удаа үнэт цаасны компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоож өгснөөр Хорооны зүгээс үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн зуучлагч байгууллагуудын үйл ажиллагаанд тодорхой шаардлага, шалгуурыг мөрдүүлж эхэлсэн.

Хорооны 2016 оны 94 дүгээр тогтоолоор баталсан “Зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоолын Хавсралт 2–т “Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд 30.0 сая төгрөг, брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд 100.0 сая төгрөг, дилерийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд 200.0 сая төгрөг, андеррайтерын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд 1,000.0 сая төгрөг”-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээтэй байх, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг эрхэлж буй үйл ажиллагаа тус бүрээр хангах ба тус заалтыг 2017 оны 01 дүгээр сарын 01–ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахаар зохицуулсан.

2019 оны эхний хагас жилийн байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөлтэй 53 үнэт цаасны компани байгаагаас Хорооны 2016 оны 94 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаагүй нэр бүхий 18 үнэт цаасны компани байна. Үүнд:

- Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагаа хангаагүйн улмаас Хорооны 2019 оны 80 дугаар тогтоолоор үнэт цаасны брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсэн 3 үнэт цаасны компани;
- Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн зарим шаардлагаа хангаагүйн улмаас Хорооны 2019 оны 79 дүгээр тогтоолоор үнэт цаасны брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсэн 13 үнэт цаасны компани;
- Холбогдох журмын шаардлага хангаагүйн улмаас хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх хүсэлт нь буцаагдсан 2 үнэт цаасны компани;

Хорооноос үнэт цаасны зах зээлд зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн 16 үнэт цаасны компанийн 4 нь хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх хүсэлтээ Хороонд ирүүлж, 1 үнэт цаасны компанийн хүсэлтийг

шийдвэрлэв.

Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд сэргээлгэх хүсэлтээ холбогдох журамд заасны дагуу Хороонд ирүүлээгүй тохиолдолд үнэт цаасны компаниудын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

### БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААР

Банк бус санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулах зорилтын хүрээнд Хорооны 2017 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх тухай” тогтоолд зааснаар ойрын 5 жилд буюу 2021 оны 02 дугаар сар хүртэл хугацаанд ББСБ–уудын хувь нийлүүлсэн хөрөнгийг Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй бол 2,500.0 сая төгрөг, Орхон аймгийн Баян–Өндөр, Дархан–Уул аймгийн Дархан сумдад 600.0 сая төгрөг, бусад аймаг, сумдад 200.0 сая төгрөгт хүргэх, энэхүү тогтоолын биелэлтийг ханган ажиллуулахаар ажиллаж байна.

Дээрх тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажилласнаар 2018 онд Хорооны хуралдаанаар 17 ББСБ–ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэн, 8 ББСБ–ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг сэргээн, 5 ББСБ–ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг хүчингүй болгосон бол 2019 оны эхний хагас жилийн байдлаар Хорооны хуралдаанаар 3 ББСБ–ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэн, 6 ББСБ–ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг сэргээн, 4 ББСБ–ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлүүлэв.

### ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЛААР

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэл 2019 оны 2 дугаар улиралд үйл ажиллагаандаа Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, журам, заавар, дүрмийг

мөрдлөг болгон ажиллалаа.

**1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хянан шийдвэрлэсэн байдал**

Банкнаас бусад санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай байгууллагууд болох үнэт цаас, даатгал, хадгаламж, зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллагын харилцагч, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс 2019 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 184 өргөдөл, гомдол ирсэнээс 176 нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн ба 8 өргөдөл хугацаандаа хянагдаж байна. Ирсэн нийт өргөдөл, гомдлыг салбараар нь ангилвал:

- Үнэт цаасны зах зээл – 49 /6 хянагдаж буй/
- Даатгалын салбар – 97 /2 хянагдаж буй/
- ББСБ–ын үйл ажиллагаа – 35
- ХЗХ–дын үйл ажиллагаа – 5

Тус Хороонд 2019 оны 2 дугаар улиралд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын тоог өмнөх онтой харьцуулахад 6.9 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Даатгалын салбарын өргөдөл гомдол 21.8 хувь, ББСБ–ын үйл ажиллагаатай холбоотой 12.9 хувиар тус тус өссөн бол, ХЗХ–дын үйл ажиллагаа, үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн тоо 16.7, 14.0 хувиар тус тус буурсан байна.

Өргөдлийн шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран тухайн өргөдлийн шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч нийт өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 22 хоног болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хоногоор уртассан нь дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд нь тухайн мэргэжлийн нарийвчилсан ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлт хийх, прокурорын байгууллагаар хянуулах ажиллагаа хийгддэг болсонтой холбоотой.

**2 Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн хохирлыг барагдуулах талаар гүйцэтгэсэн ажил**

2019 оны 2 дугаар улирлын байдлаар өргөдөл, гомдлыг барагдуулах хүрээнд мэргэжлийн байгууллагуудад үүрэг, даалгавар өгөх, тайлбар, мэдээ авах, мэдэгдэл өгөх зэрэг хугацаатай нийт 185 албан бичгийг хүргүүлж, хяналт тавин биелэлтийг хангуулсан ба өргөдөл гаргагчдад нийт 156 албан бичгээр Хорооны шийдвэрийг хүргүүлж ажиллав. Мөн энэ хүрээнд Хорооны холбогдох нэгжүүдээс

Газар хоорондын 2 бичгээр мэдээлэл, лавлагаа авчээ.

Чиглэлийн хэмжээнд даатгуулагч 22 иргэн, хуулийн этгээдийн нөхөн төлбөрт нийт 449.9 сая төгрөгийг олгуулах шийдвэрийг гаргаж, үүнээс нэр бүхий 9 иргэн, хуулийн этгээдэд нийт 110.1 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулсан байна.

**3 Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх санал боловсруулсан байдал**

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зах зээлийн мэдээлэлд суурилсан судалгаа, шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах, мөрдөгдөж буй дүрэм, журмыг сайжруулах, боловсронгуй болгох зорилгоор өргөдөл, гомдлын мэдээллийн 2017–2018 оны өргөдөл, гомдлын дэлгэрэнгүй мэдээллийн санг зохицуулалтын салбар бүрээр бий болгож боловсруулах ажлыг зохион байгуулсан ба өргөдөл гомдлын 2016–2019 онуудын судалгааг улирал бүрээр гаргаж Хорооны цахим хуудсанд байршуулж байна.

Хорооны цахим хуудас болон “Хүртээмжтэй санхүү” товхимлын “Хэрэглэгч” буланд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах талаарх мэдээллийг тогтмол оруулав.

Мөн чиглэлийн ажилнууд нийт 350 гаруй иргэнд мэргэжлийн зөвлөгөө, тодруулгыг утсаар болон биечлэн уулзаж өгчээ.

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж санхүүгийн зах зээлийг бүхэлд нь хамарсан санхүүгийн маргаан шийдвэрлэх механизмын эрх зүйн тогтолцоог бий болгох чиглэлээр Монголбанкт хамтран 6 орнуудын харьцуулсан судалгааг хийсэн бөгөөд хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Хуулийн төсөлд санхүүгийн хэрэглэгч, үйлчилгээ үзүүлэгчийн тодорхойлолт, тэдгээрийн эрх, үүрэг, санхүүгийн гэрээ байгуулахаас өмнөх шат /мэдээллийн ил тод байдал/–наас дуусах шатанд санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах /өргөдөл гомдол барагдуулах үйл ажиллагаа/ болон маргаан гарсан тохиолдолд шүүхийн өмнөх шатнын хараат бус нийт санхүүгийн зах зээлийн омбудсмэний харилцааны зохицуулалтыг тусгуулсан.

**4 Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн ажил**

“Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр 2016–2021”–ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж байна.

Мөн Монгол Улсад банк, санхүүгийн байгууллага үүсэн байгуулагдсаны 95,

санхүүгийн зохицуулагч байгууллага үүссэний 25 жилийн ойд зориулан “Санхүү банкны эмэгтэйчүүдийн анхдугаар чуулган”–ыг 2019 оны 3 дугаар сарын 27–ны өдөр зохион байгуулагчаар хамтран оролцжээ.

**УЛСЫН БАЙЦААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Хороо тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх болон зайны хяналтын явцад зохицуулалтын байгууллагууд холбогдох хууль, Хорооны тогтоолоор баталсан журам зааврыг хэрэгжүүлэхгүй байх, мөн зөрчих үйлдэл гаргасан тохиолдолд тухайн байгууллагад улсын байцаагч нар албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг нь хангуулж ажилласан.

**Хорооноос 2019 онд хийгдсэн газар дээрх шалгалт болон зайны хяналтаар:**

Даатгалын компани өөрийн дүрмийн болон нөөц сангийн мөнгийг холбогдох этгээдийн үүсгэн байгуулсан банкинд байршуулсан, хохирлын нөхөн төлбөрийг олгохоос үндэслэлгүй татгалзсан, мөн олгоогүй, төлбөрийн чадварын чадварын шалгуур үзүүлэлт нь журамд заасан хэмжээнд хүрэхгүй болсон, даатгалын бүтээгдэхүүний Хороонд бүртгүүлээгүй, даатгалын зуучлагч, хохирол үнэлэгч нар аймаг орон нутагт зөвшөөрөлгүй салбар нээж ажиллуулсан, санхүүгийн тайланг хууль журамд заасан хугацаанаас хоцроох, тоон мэдээллийг зөрүүтэй ирүүлэх зэрэг илэрсэн дутагдлуудыг засаж арилгах, хэрэгжүүлэхээр 11 улсын байцаагчийн албан шаардлага бичиж хэрэгжилтэд хяналт тавьж гүйцэтгэлийг хангуулсан.

Банк бус санхүүгийн байгууллагууд нягтлан бодох бүртгэлийн программ хангамжгүй, өөрчлөгдсөн хаяг байршлаа Хороонд бүртгүүлээгүй, хуулиар хориглосон хадгаламж авсан, тайлан мэдээ ирүүлээгүй, холбогдох этгээдэд зохистой харьцаанд заасан хэмжээнээс хэтрүүлэн зээл олгосон, хувьцаат компаниар ажиллаж буй ББСБ Хөрөнгийн биржийн цахим хаягт Хорооны баталсан журмын дагуу мэдээллийг нийтлээгүй, нягтлан бодох бүртгэлээ ББСБ–ын НББ–ийн үлгэрчилсэн зааврын дагуу хөтлөөгүй зэрэг дутагдлуудыг арилгах хэрэгжилтийг хангуулахаар 7 улсын байцаагчийн албан шаардлага бичиж хэрэгжилтэд хяналт тавьж, мөн хангуулж ажилласан.

Хадгаламж зээлийн хоршоонууд санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг журамд заасан хугацаанд ирүүлээгүй, зөвшөөрөлгүйгээр салбар нээж ажиллуулсан, хоршооны гишүүн бус этгээдэд зээл олгосон, гишүүнээс хасахдаа иргэнд мэдэгдээгүй зэрэг дутагдлуудыг арилгуулахаар 13 улсын байцаагчийн албан шаардлага бичиж

хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Үнэт цаасны компаниуд мөнгө угаах МУТСТ хөтөлбөртэй болох, мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хангах, үнэт цаасны зах зээлд ажиллах эрх авах, хаягийн өөрчлөлт хийх, зохицуулалт үйлчилгээний хөлс төлөх, хувьцаат компани болон бусад зохицуулалтай этгээдэд тусгаарласан хувьцааг чөлөөлөх, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, зөрчлийн хэрэгтэй холбоотой материал гаргуулах зэргээр 8 улсын байцаагчийн албан шаардлага бичиж хэрэгжилтийг хангуулж ажилласан.

Хорооны улсын байцаагчид 2019 онд зохицуулалтын байгууллагын үйл ажиллагаанд хийсэн газар дээрх шалгалт болон зайны хяналтаар нийт 39 улсын байцаагчийн албан шаардлага бичиж тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж гүйцэтгэлийг хангуулан ажилласан. Улсын байцаагчийн албан шаардлага нь зохицуулалтын байгууллагуудад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад, тэдгээрийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн явуулахад ихээхэн ач холбогдолтой байгаа болно.

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР**

Зөрчлийн тухай хуулийн 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан, зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль нь 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн зорилт нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчлийг шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг 2017.07.01-ний өдрөөс эхлэн даган мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны нийт 29 хянан шалгагч бүхий эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.18-д заасан зөрчлүүдийг харьяаллын дагуу шалган шийдвэрлэж байна.

Хороонд 2019 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар зөрчлийн шинжтэй 113 гомдол мэдээлэл бүртгэгдэж Хорооны хянан шалгагч нар дараах байдлаар шалгаж шийдвэрлэсэн байна.




Улсын ерөнхий прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор нар дээрх зөрчлийн хэргүүдэд хяналт тавин ажилласан.

Зөрчлийн хэрэг нээсэн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх хуульд зааснаар зөрчлийн хэрэг нээснээс 14 хоногт, шаардлагатай тохиолдолд зөрчлийн хэрэг бүртгэлийг удирдах албан тушаалтан 14 хоног, прокурор

30 хоног тус тус сунгаж нийт 58 хоногт багтаан зөрчлийн хэрэг бүртгэлт явуулж шийдвэрлэнэ. Зөрчлийн хэргийг нэг эсвэл хэд хэдэн эрх албан тушаалтныг зөрчлийн хэргийн эрх бүхий албан тушаалтан томилно.

Эрх бүхий албан тушаалтан нь хуульд прокурорын зөвшөөрлөөр явуулахаар зааснаас бусад ажиллагааг явуулах шийдвэрийг бие даан гаргаж болно.

**Зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэсэн байдал дараах байдалтай байна. Үүнд:**



Хуулийн этгээд, хувь хүн нь дараах нийтлэг зөрчил дутагдлыг гаргаж торгуулийн арга хэмжээ авагдсан байна. Үүнд:

### 1. Даатгалын чиглэлд–20 гомдол

- Хорооны зөвшөөрөлгүй даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогч компаниуд нь салбарын үйл ажиллагаа эрхэлсэн;
- Эрх бүхий албан тушаалтныг Хорооны зөвшөөрөлгүй томилсон;
- Даатгалын төлөөлөгч, зуучлагчийн эрхгүй хувь хүн хуулийн этгээдэд даатгалын хураамжийн орлогын шимтгэл төлсөн;
- Нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтлөөгүй, анхан шатны баримт бичгийн хөтлөлт хангалтгүй;
- Давхар даатгалын төлөвлөгөө, тайланг Хороонд ирүүлээгүй;

### 2. Хадгаламж, зээлийн хоршооны чиглэлд–14 гомдол

- Хадгаламж зээлийн хоршооны гишүүдийн мөнгөн хадгаламжийг гишүүний анхны шаардлагаар олгоогүй;
- Хоршооны гишүүн бус этгээдэд зээл олгосон;
- Хороонд бүртгэлгүй хаяг байршилтай;
- Хуулийн хугацаанд хувь нийлүүлэгчийн хурлаа хийгээгүй;
- Хоршооны гишүүнд мэдэгдэлгүй ХЗХ–ын гишүүнээс хассан
- Хорооны зөвшөөрөлгүй салбарын үйл ажиллагаа эрхэлсэн;

### 3. Банк бус санхүүгийн чиглэлд–17 гомдол

- Төлбөр тооцоо, ажил гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгээгүй;
- Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн;
- Хуулиар хориглосон мөнгөн хадгаламж татсан;
- Хорооны зөвшөөрөлгүй салбарын үйл ажиллагаа эрхэлсэн;

### 4. Үнэт цаасны чиглэлд–62 гомдол

- Хувьцаат компанийн хувьцааны үнийг хөрөнгийн бирж дээр зохиомлоор өсгөсөн;
- Нийтэд мэдээлэх нээлттэй мэдээллийг мэдээлэх үүргээ биелүүлээгүй;

- Төлбөр тооцоо, ажил гүйлгээг валютаар илэрхийлсэн;
- Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах ХАА–н гаралтай түүхий эдийг биржээр арилжаалахгүй экспортод гаргасан;
- Компанийн бонд, үнэт цаасыг Хорооны зөвшөөрөлгүй гаргасан, хаалттай хүрээнд гаргасан бондыг олон нийтэд сурталчилсан;
- Компанийн нэгдсэн санхүүгийн тайлан гаргах үүргээ биелүүлээгүй;
- Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүй эрхэлсэн;
- Хорооны зөвшөөрөлгүй үнэт цаасны брокер, дилерийн салбарын үйл ажиллагаа эрхэлсэн зэрэг болно.

Хорооны эрх бүхий албан хаагчдад Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт, зөрчил шалган шийдвэрлэхтэй холбоотой талаар УПЕГ болон бусад холбогдох газраас сургалтыг зохион байгуулсан байна.

## УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БҮРТГЭХ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ ХЭЛТСЭЭС ИРҮҮЛСЭН ТООН МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн зохицуулах хороонд ирсэн гомдол мэдээллийг эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэсэн байдал. /2019.06.24 –ний байдлаар/

Шийдвэрлэсэн байдал	2018 он	2019 он
Гомдол мэдээлэл	83	15
Хялбаршуулсан	25	10
Зөрчлийн хэрэг нээсэн	21	4
Хүлээн авахаас татгалзсан	37	1
<b>Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэргээс шийтгэл оногдуулсан</b>		
Хувь хүн	1	2
Хуулийн этгээд	41	0

## 2019 ОНД БОЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2019.7.24–26

Олон улсын хоршоодын зохицуулагчдын сүлжээ (ICURN)–ний ээлжит чуулган АНУ

2019.9.09–13

СХН (AFI)–ийн ээлжит Дэлхийн бодлогын форум Руандагийн Бүгд Найрамдах Улс



Монгол Улс, Улаанбаатар хот 15160  
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3  
Засгийн газрын IV байр.



+976-51-264444



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



Санхүүгийн зохицуулах хороо